



**“АЖИГЛАЛТ”  
ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА**

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН  
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ  
2023 он**

## **АГУУЛГА**

### **БҮЛЭГ 1.**

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ, АРГА ЗҮЙ, СУДАЛГААНЫ БАГ

### **БҮЛЭГ 2.**

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ЧИГ ҮҮРГИЙН ҮНЭЛГЭЭ

- 2.1. Төрийн жинхэнэ албаны ерөнхий болон тусгай шалгалт зохион байгуулах
- 2.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх
- 2.3. Маргаан хянан шийдвэрлэх
- 2.4. Сургалт судалгаа зохион байгуулах, мэдээллийн нэгдсэн санг эрхлэх
- 2.5. Мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгөх

### **БҮЛЭГ 3.**

БУСАД ЧИГЛЭЛЭЭР

- 3.1. Төрийн албаны шинэтгэлтэй холбогдсон чиг үүргийн хэрэгжилт

**ДҮГНЭЛТ  
ЗӨВЛӨМЖ**

## **БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ, АРГА ЗҮЙ**

### **1.1. Судалгааны зорилго, зорилт**

Монгол Улсын Төрийн албаны зөвлөл нь холбогдох хууль тогтоомж, түүний дотор Төрийн албаны тухай хууль болон Улсын Их Хурал (УИХ)-аас баталсан Зөвлөлийн дүрмээр хүлээсэн чиг үүрэг, тухайн жилийн зорилт, төлөвлөсөн хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийн өнөөгийн байдал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг тогтоохоор “Байгууллагын үйл ажиллагаа буюу чиг үүргийн үнэлгээ” хийлгэсэн болно.

Төрийн албаны зөвлөлийн хуулиар тогтоосон чиг үүрэг, өнөөгийн байдал, үйлчилгээний чанар, хүртээмжтэй байдал, тулгамдаж буй асуудлыг чиг үүргийн шинжилгээний арга зүйд тулгуурлан мониторинг хийж цаашдын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн санал, зөвлөмжийг өгөхөд чиглэсэн болно.

Төрийн албаны зөвлөлийн өнөөгийн гүйцэтгэж буй чиг үүргийг ангилан, шинжилснээр цаашид байгууллагыг хөгжүүлэх арга замуудыг тодорхойлж, төрийн албаны салбарын шинэтгэлд өөрчлөлт хийхэд дэмжлэг болох юм.

### **1.2. Судалгааны арга, арга зүй**

Үнэлгээг УИХ-ын Байнгын хорооны 2013 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, эрх зүйн бусад акт, үйл ажиллагааны тайлан, тоо баримт гэх мэт мэдээллийн эх сурвалжийг судалж, баримт бичгийг нягтлах, дүн шинжилгээ хийх аргаар хийлээ.

Байгууллагын чиг үүргийн үнэлгээ хийхдээ богино хугацаанд баримт бичигт дүн шинжилгээ хийх, дүгнэлт гаргах, зөвлөмж бичих, тайлан гаргах, Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх үе шаттай ажлуудыг гүйцэтгэсэн болно.

Энэхүү зорилгод хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэв. Үүнд:

Хөндлөнгийн мониторинг судалгааны зорилго нь Төрийн албаны зөвлөлийн хуулиар тогтоосон чиг үүргийн хүрээнд иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар, шуурхай байдал, хүртээмжийн бодит байдлыг үнэлэхэд чиглэнэ.

### **1.3. Судалгааны түүвэр ба хамрах хүрээ**

Төрийн албаны зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөний биелэлт зэрэг холбогдох баримт бичгүүд, төрийн албаны шалгалт өгч байсан болон өгөхөөр бүртгүүлж буй иргэн, тусгай сонгон шалгаруулалтад орж буй иргэн, ТАЗ-ийн зарим удирдлага, албан хаагчтай ярилцлага хийх, асуулгын хуудсаар мэдээлэл авах, тухайн үйлчилгээ үзүүлж буй газарт судлаач өөрийн биеэр очин ажиглалт хийх зэргээр судалгааны үндсэн мэдээллийг 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөс 3 дугаар сарын 13-ны өдрийн хооронд цуглуулсан болно.

Нийтдээ тус байгууллагад 5 удаа ажиглалт хийж, мониторингийн хуудасны бүртгэл хийсэн. Мөн тус байгууллагын албан хаагч болон иргэд үйлчлүүлэгч болох 24 хүнээс асуумж, тодруулга, ганцаарчилсан ярилцлага хийсэн байна.

Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны зорилго, зорилт нь төрийн албаны чадахуй /мерит/-н зарчмыг сахиулж, улс төрийн зүй бус нөлөөллөөс ангид, иргэдийн итгэл хүлээсэн төрийн албыг төлөвшүүлэх, Төрийн албаны тухай хуульд заасан бүрэн эрх, чиг үүргийнхээ хүрээнд төрийн албаны мэргэшсэн, тогтвортой, ил тод, хариуцлагатай, ёс зүйтэй байдлыг хангахад чиглэнэ<sup>1</sup>.

Төрийн албаны зөвлөлийн дүрэмд тусгагдсан чиг үүргүүдийн хэрэгжилтэд бүхэлд нь үнэлгээ хийхэд цаг хугацааны болон хүний нөөц, санхүүгийн хэрэгцээ ихээр шаардагдах тул зөвлөлийн жилийн ажлын тайланд үндэслэн байгууллагын чиг үүрэгт хийх үнэлгээний үндсэн хүрээг дараах арга хэмжээний үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр тогтоосон. Үүнд:

1. *Төрийн жинхэнэ албаны ерөнхий болон тусгай шалгалт зохион байгуулах*
2. *Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх*
3. *Маргаан хянан шийдвэрлэх*
4. *Сургалт судалгаа зохион байгуулах, мэдээллийн нэгдсэн санг эрхлэх*
5. *Мэргэшил арга зүйн зөвлөгөө өгөх*

Үйл ажиллагааны дээрх 5 чиг үүргийн хүрээнд хэсэгчлэн үнэлгээ хийж, дүгнэлт бичиж, нэгдсэн зөвлөмж боловсруулснаас гадна дараах бүлгээр ангилан үнэлэлт өгсөн болно. Үүнд:

1.Төрийн албаны шинэтгэлтэй холбогдсон чиг үүргийн хэрэгжилт

### ***Түүврийн шалгуур***

Стандартчилагдсан ярилцлагад хамрагдах үйлчлүүлэгч дараах шалгуурыг хангасан байна:

- 18-аас дээш настай байх
- Судалгаа авч байх үед тухайн шатны байгууллагаас ямар нэгэн үйлчилгээ авсан болон авахаар бүртгүүлсэн байх гэсэн шалгуурыг тус тус оноосон болно.

### ***1.4. Мэдээлэл цуглуулах арга***

#### **Судалгааны үндсэн аргууд**

Судалгааны мэдээллийг үйлчлүүлэгчээс авах асуумж, байгууллагын төлөөлөлтэй хийх ярилцлага, баримт бичгийн судалгаа, ажиглалтын хуудас гэсэн тоон болон чанарын судалгааны аргуудыг ашиглан цуглуулав.

#### **Баримт бичгийн судалгаа**

Тухайн байгууллагын үйл ажиллагааг үнэлэхийн тулд тухайн салбарын хууль тогтоомжийг судлахаас гадна байгууллагын холбогдох баримт бичгүүдийг цуглуулж дүн шинжилгээ хийсэн болно.

---

<sup>1</sup> УИХ-ын 2019 оны 17 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 1.6, 1.7 дахь хэсгийн заалт

### **Асуумж / Анкет**

Судалгааны асуумжид дээр дурдсан шалгуур үзүүлэлтийг багтаасан бөгөөд захиалагч талын санал зөвлөмжийг тусгахын зэрэгцээ, арга зүйн хувьд харьцуулан судлах, боловсруулах боломжтой, цаашид авч хэрэгжүүлэх бодлого шийдвэрүүдэд дэмжлэг үзүүлж болохуйц асуултуудыг оруулав.

Асуумжийг авахдаа Төрийн албаны зөвлөлөөр үйлчлүүлсэн иргэдийн сэтгэл ханамжийг тодорхойлох зорилгоор явуулав. Судлаач тухайн иргэнээс илүү их мэдээлэл гүнзгийрүүлэн авахын тулд асуумжийн зарим асуултыг хагас бүтэцчилэгдсэн асуумжийн дагуу судалгаанд оролцогчтой ярилцах, асуух аргаар авч асуумжийг бөглөсөн.

Судалгаанд хамрагдахаас өмнө оролцогчдод ямар зорилгоор хаанаас судалгаа явуулж байгааг хувийн мэдээллийг нь нууцлах талаар тайлбарлан албан ёсоор зөвшөөрөл авсан.

### **Ажиглалтын хуудас**

Судалгаа явагдсан цэг бүрт нэг ажиглалтын хуудас бөглөсөн. Ажиглалтын хуудас нь тухайн үйлчилгээний орчин нөхцөлийг үнэлэх гол хэрэглэгдэхүүн юм.

Орчин нөхцөлийг дүрсэлж болохуйц зүйлсийг ажиглалтын хуудаст оруулсан бөгөөд судлаачийн субъектив нөлөөллийг бууруулахын тулд хэрхэн үнэлсэн талаарх тэмдэглэлийг тайлбар хэсэгт асуулт тус бүрт оруулж өгсөн.

### **Ганцаарчилсан ярилцлага**

Ганцаарчилсан ярилцлагаар тоон судалгаагаар төдийлөн илрэх боломжгүй тухайн салбартай холбоотой асуудлыг илрүүлэн гаргаж ирэхийг зорьсон. Тухайн байгууллагын албан хаагчтай хийх асуумж, ярилцлагын үед оролцогчид тухайн асуудлыг нөгөө талаас нь тодруулах, шалтгаан нөхцөлийг илүү гүнзгий тайлбарлах боломжтой байдаг.

## ***1.5.Мэдээллийн дүн шинжилгээ***

**Тоон судалгааны шинжилгээ:** Ажиглалтын хуудас болон анкетын анхдагч мэдээллийг MS EXCEL програмд шивж оруулсан бөгөөд энэ явцад гарах алдааг 2 хувиас хэтрүүлэхгүйг зорьж ажилласан. Шивж оруулсан мэдээллийг бөглөсөн асуулгатай тулган шалгаж, мэдээлэл программд алдаагүй орсон эсэхийг нягтлаад механик болон логик алдааг шалгаж чанарын шаардлагад нийцүүлэн боловсруулалт хийлээ.

Тоон судалгааны мэдээллийн боловсруулалтад сонирхож байгаа үзүүлэлтийн дан тоололтоос гадна харьцуулсан шинжилгээний аргыг өргөнөөр ашиглав.

**Чанарын судалгааны шинжилгээ:** Ганцаарчилсан ярилцлагын мэдээллийн зарим кейс жишээг шигтгээ байдлаар давхар оруулж өгсөн нь илүү бодитой дүр зургийг харуулахад тусална.

## **1.6.Мониторингийн хязгаарлагдмал тал**

### **Түүвэр харьцангуй байх тохиолдол:**

Төрийн албаны зөвлөлийн үндсэн үйл ажиллагаа нь Улаанбаатар хотод төвлөрч явагддаг бөгөөд яам, агентлагууд, аймаг нийслэлийн нийт 52 салбар зөвлөлийг мэргэшил, арга зүйн нэгдсэн удирдлага, зөвлөмж, чиглэлээр ханган ажилладаг.

Иргэд, байгууллагуудад цахимаар болон биечлэн бүртгэх, бүх шатны шалгалтыг зохион байгуулах гэх зэрэг үйлчилгээ үзүүлдэг байна. Үйлчлүүлэгчдийн эрэлтийн харьцангуй байдлаас үүдэн судалгааны мэдээлэл цуглуулах хугацаанд үйлчлүүлэгчдийн тоог жигд хамруулах боломжгүй байсан бөгөөд төсөв санхүүгийн хэмнэлтийн бодлогын улмаас орон нутагт ажиллах боломжгүй байсан нь хязгаарлагдмал тал болно.

Мөн байгууллагын үйл ажиллагаа, иргэдийн сэтгэл ханамжийг судлахын тулд тухайн байгууллагын үйл ажиллагаанд гаргасан санал гомдолд баримт бичгийн судалгаа хийсэн бөгөөд тухайн хувь хүн болоод байгууллагын нууц гэсэн үүднээс зарим талаар хязгаарлагдмал нөхцөлд танилцах боломжтой байсныг дурдах нь зүйтэй. Мөн зарим нэгэн иргэдтэй уулзахад энэ талаар дургүйцэл илэрхийлэх, болгоомжлох, эсрэгээр өөрийн хувийн баримт бичиг, холбогдох материалыг дэлгэрэнгүй үзүүлж харуулах, зураг авхуулахыг үл зөвшөөрөх, асуулт ярилцлагад төвийг сахисан байдлаар хандаж байсан болно.

Энэ нь энэхүү судалгааны хоёр дахь хязгаарлагдмал тал болно.

### **СУДАЛГААНЫ БАГ**

Л.Энхбаяр

Багийн ахлагч, Ажиглалт

Б.Алтанцэцэг

Судалгааны зохицуулагч, Ажиглалт

Д.Жаргалсайхан

Судалгааны зохицуулагч, Ажиглалт

Энэхүү “Төрийн албаны зөвлөлийн 2022 оны үйл ажиллагаанд хийсэн чиг үүргийн үнэлгээний тайлан”-г “Ажиглалт” төрийн бус байгууллага 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн 03 дугаар сарын 13-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэв.

Тус тайланд тусгагдсан дүгнэлтүүд зөвхөн судалгааны багийн гишүүдийн байр суурийг илэрхийлж буй болно.

---oOo---

## БҮЛЭГ 2. ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ЧИГ ҮҮРГИЙН ҮНЭЛГЭЭ

### 2.1. ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАНЫ ЕРӨНХИЙ БОЛОН ТУСГАЙ ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ

Төрийн албанд ажиллах иргэдэд адил тэгш боломж олгох үндсэн механизм болох төрийн албаны ерөнхий шалгалтыг аймаг, нийслэлийн салбар зөвлөлүүд, төрийн байгууллагуудтай хамтран 2022 онд 2 удаа зохион байгуулсан байна. 2 удаагийн төрийн албаны ерөнхий шалгалтад 13559 иргэн бүртгүүлснээс 11180 иргэн оролцож, 3739 иргэн буюу шалгалтад оролцогчдын дунджаар 33.4 хувь нь төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцөд бүртгэгдсэн байна.

Цахим системийг төрийн албаны ерөнхий шалгалтын үйл ажиллагаанд нэвтрүүлж шалгалтын зар, бүртгэл, шалгалтын дүн зэрэг мэдээллийг ил тод нээлттэй болгосон байна.

Төрийн албаны зөвлөлийн гишүүд Дундговь, Өмнөговь, Баянхонгор, Орхон аймгуудаар явж Төрийн албаны ерөнхий шалгалтын бэлтгэл, явц, зохион байгуулалттай танилцаж, арга зүйн зөвлөгөө, мэдээллээр хангаж ажиллажээ.

#### Төрийн албаны ерөнхий шалгалтын мэдээлэл /2019-2022 он/

##### 1. Ерөнхий мэдээлэл

Төрийн албаны ерөнхий шалгалтын мэдээлэл						
		2019	2020	2021	2022	
<b>Төрийн албаны ерөнхий шалгалтад бүртгүүлсэн иргэдийн тоо</b>		8894	16218	22299	13559	60970 /давхардсан байдлаар/
<b>Үүнээс</b>	Төрийн албаны ерөнхий шалгалт өгсөн хүний тоо	7616	12286	17292	11180	48374
	Шалгалтад тэнцэж нөөцөд бүртгэгдсэн хүмүүсийн тоо	<b>1116</b>	<b>3823</b>	<b>5484</b>	<b>3739</b>	<b>14162</b>
	Ерөнхий мэдлэгийн шалгалтад тэнцсэн хүний тоо	1588 /дундаж оноо-38.5/	5017 /дундаж оноо-41.3/	7343 /дундаж оноо-41.1/	4991 /дундаж оноо-41.2/	18939
	Монгол хэл бичгийн чадварын шалгалтад тэнцсэн хүний тоо	1443 /дундаж оноо-25.9/	4070 /дундаж оноо-24.5/	5858 /дундаж оноо-24.5/	3944 /дундаж оноо-24.6/	15315
	Дүн шинжилгээ хийх чадварын шалгалтад тэнцсэн хүний тоо	1116 /дундаж оноо-12.1/	3823 /дундаж оноо-13.2/	5484 /дундаж оноо-13.2/	3739 /дундаж оноо-13.4/	14162

Төрийн албаны ерөнхий шалгалтад бүртгүүлсэн иргэдийн насны ангилал, хүйсийн харьцаа, төгссөн сургууль, мэргэжил, боловсрол, онооны ангиллын байдлаар статистик мэдээг тогтмол гарган мэдээлж байна.

2022 оны төрийн албаны ерөнхий шалгалтад тэнцсэн 3739 иргэний тэнцсэн тухай мэдээллийг Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсанд байршуулснаас гадна төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаал, төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтын дүн, тайлан мэдээг тухай бүр авч, судалгааг тогтмол шинэчилж ажилласан байна.

Тусгай шалгалтын цахим системийг хөгжүүлэлт хийж, шалгалтын шинэ цахим системийг нэвтрүүлсэн бөгөөд ТАЗ болон түүний УБ хот, аймаг нийслэл дэх байгууллагуудын салбар зөвлөлүүд шинээр хөгжүүлсэн цахим системээр тусгай шалгалт, төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж байна.

Тусгай шалгалт /тухайн албан тушаалын/ болон

Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтын зар

Салбар, Зөвлөлийн нэрээр хайж...				
<b>Төрийн албаны зөвлөл зохион байгуулах</b> Зарласан сул орон тоо <b>154</b>	<b>Үндэсний статистикийн хорооны дэргэдэх салбар зөвлөл зохион байгуулах</b> Зарласан сул орон тоо <b>19</b>	<b>Саягийн яамны дэргэдэх салбар зөвлөл зохион байгуулах</b> Зарласан сул орон тоо <b>80</b>	<b>Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх салбар зөвлөл зохион байгуулах</b> Зарласан сул орон тоо <b>17</b>	<b>Боловсрол, шинжлэх ухааны яамны дэргэдэх салбар зөвлөл зохион байгуулах</b> Зарласан сул орон тоо <b>16</b>
<b>Зам, тээврийн хөгжлийн яамны дэргэдэх салбар зөвлөл зохион байгуулах</b> Зарласан сул орон тоо <b>10</b>	<b>Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх салбар зөвлөл зохион байгуулах</b> Зарласан сул орон тоо <b>19</b>	<b>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх салбар зөвлөл зохион байгуулах</b> Зарласан сул орон тоо <b>32</b>	<b>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны дэргэдэх салбар зөвлөл зохион байгуулах</b> Зарласан сул орон тоо <b>25</b>	<b>Эрчим хүчний яамны дэргэдэх салбар зөвлөл зохион байгуулах</b> Зарласан сул орон тоо <b>18</b>
<b>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэдэх салбар зөвлөл зохион байгуулах</b> Зарласан сул орон тоо <b>21</b>	<b>Эрүүл мэндийн яамны дэргэдэх салбар зөвлөл зохион байгуулах</b> Зарласан сул орон тоо <b>51</b>	<b>Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөл зохион байгуулах</b> Зарласан сул орон тоо <b>5</b>	<b>Мэргэжлийн хангалтын ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөл зохион байгуулах</b> Зарласан сул орон тоо <b>20</b>	<b>Гадаадын иргэн харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөл зохион байгуулах</b> Зарласан сул орон тоо <b>24</b>

Тус цахим системийн талаар Салбар комисс болон шалгалтад бүртгүүлсэн иргэд олон нийт сэтгэгдэл өндөр байгаа төдийгүй тусгай шалгалтад бүртгүүлэх, шалгах, дүгнэх зэрэг шалгалтын бүхий л процессыг цахим хэлбэрт шилжүүлснээр хүний оролцоо, хөндлөнгийн нөлөөлөлгүй, олон нийт, мэргэжлийн байгууллагуудын хяналтын дор ил тод, нээлттэй байдлыг бүрдүүлсэн байна гэж дүгнэсэн болно.

Төрийн албаны ерөнхий шалгалтын сорилын санг нягтлан шалгаж салаа утгатай, шаардлага ур чадварт нийцээгүй, эргэлзээтэй байж болохуйц сорилуудыг хасч шалгалтын үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлсэн бөгөөд шалгалтад оролцогчдоос сорил алдаатай, эргэлзээтэй гэсэн асуудлаар өргөдөл, гомдол гаргаагүй байна.

Төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан байдал:

№	Сонгон шалгаруулалт зохион байгуулсан байгууллага	Зарласан сул орон тоо	Удирдах албан тушаал	
			нэр дэвшсэн сул орон тоо	нөхөгдөөгүй сул орон тоо
1	Төрийн албаны зөвлөл	231	207	24
2	Төрийн албаны зөвлөлийн Яамдын дэргэдэх салбар зөвлөл	607	529	78
3	Төрийн албаны зөвлөлийн Агентлагуудын дэргэдэх салбар зөвлөл	762	603	159
4	Төрийн албаны зөвлөлийн Аймаг, нийслэлийн салбар зөвлөл	4171	2166	2005
Нийт		5771	3505	2266



## ТӨРИЙН АЛБАНЫ ШАЛГАЛТ ӨГӨХӨД БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

**Салбар комисс**



**Төрийн албан хаагчийн шалгалтанд бүртгэгч иргэн**



**БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ**

- Хүсэлт;
- Анкет;
- Баримт бичгийн хуулбар;
- Иргэний үнэмлэх;
- Цээж зураг;
- Үйлчилгээний зардал төлсөн баримт;
- Цэргийн алба хаасан тухай баримт;
- Хөгжлийн бэрхшээлтэй бол нотолсон баримт;

Дээр заасан баримт бичгийг дутуу бүрдүүлсэн, зохих ёсоор бүрдүүлээгүй иргэнийг бүртгэхгүй!!!

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дугаар тогтоол - "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам"

Төрийн албаны ерөнхий шалгалтад хүний оролцоо, хөндлөнгийн нөлөөлөлгүй, олон нийт, мэргэжлийн байгууллагуудын хяналтын дор ил тод, нээлттэй зохион явуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор бүртгэх, шалгах, үнэлж дүгнэх бүх процессыг цахимжуулсан байна. Шалгалтад бэлтгэх үйл ажиллагааг онлайн хэлбэрээр болон иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн сорил, хариултыг ном болгон хэвлүүлж, түгээсэн нь шалгалтын үр дүнд эергээр нөлөөлөх сайн талтай юм.

Төрийн албаны зөвлөлөөс төрийн албаны шинэтгэлийн цоо шинэ хандлага болох төрийн албанд цахимжилтыг нэвтрүүлэх талаар олон талт ажлыг өрнүүлэн амжилттай ажиллаж байна. Цахимжилтыг төрийн албанд өргөн хүрээтэй нэвтрүүлснээр хүнд суртал шат дамжлагыг багасгах, төрийн үйлчилгээний хөнгөн шуурхай байдлыг хангах, төсөв зардал хүн хүч хэмнэх, үйл ажиллагааны ил тод байдал болон иргэд олон нийтийн хүсэн хүлээлтийг хангах зэрэг олон эерэг сайн талтай юм.

### **Төрийн жинхэнэ албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан байдал**

	Сонгон шалгаруулалт			Сул орон тоо		
	бүртгүүлэх			шалгалтад оролцсон хүн	нэр дэвшсэн сул орон тоо	нөхөгдөөгүй сул орон тоо
	хүсэлт өгсөн	шаардлага хангасан	шаардлага хангаагүй			
Төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын зарласан сул орон тоо	<b>8357</b>	<b>5449</b>	<b>2908</b>	<b>5003</b>	<b>3505</b>	<b>2266</b>
<b>5771</b>						

Төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалтад нийт 8357 хүн бүртгүүлэх хүсэлт ирүүлснээс 2908 хүн тухайн албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлага хангаагүй, тусгай шалгалтын журамд заасан сул орон тоог нөхөх дарааллыг хангаагүй тул оролцуулах боломжгүй гэж шалгалтын комиссоос шийдвэрлэсэн байна.

2022 онд нийт нөхөгдсөн удирдах болон гүйцэтгэх албан тушаалын 3505 сул орон тооны 899 нь төрийн жинхэнэ албан тушаал эрхэлж байгаа албан хаагчийн нөөцөөс, 234 нь төрийн албанаас сургалт, эрүүл мэнд, бүтэц зохион байгуулалтын болон бусад байдлаар чөлөөлөгдсөн иргэний нөөцөөс, 2372 нь төрийн жинхэнэ албаны ерөнхий шалгалт өгч тэнцсэн иргэдийн нөөцөөс тус тус нөхөгдсөн байна.

2022 онд төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын 3505 сул орон тоо нөхөгдсөнөөс тэргүүн түшмэлийн албан тушаалд 10, эрхэлсэн түшмэлийн албан тушаалд 104, ахлах түшмэлийн албан тушаалд 326, дэс түшмэлийн албан тушаалд 2794, туслах түшмэлийн албан тушаалд 271 иргэн тус тус томилогдсон байна.

**Дүгнэлт: “Төрийн жинхэнэ албаны ерөнхий болон тусгай шалгалт зохион байгуулах” чиг үүргийг төрийн жинхэнэ албаны сонгон шалгаруулалтын эрх зүйн орчин, төрийн жинхэнэ албаны ерөнхий шалгалт болон тусгай шалгалт, төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалт гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд авч үзээд, хэрэгжилтийг 95% гэж дүгнэлээ.**

## 2.2. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ

Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээний ажлын хүрээнд: Төрийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол төв байгууллага өөрөө, эсхүл иргэний гомдол, мэдээллийн дагуу төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж томилох үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийнэ” гэж, 30.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 30.1-д заасан хяналт, шалгалтын явцад хууль тогтоомж зөрчиж сонгон шалгаруулалт явуулсан, төрийн албан хаагчийг томилсон нь тогтоогдсон бол зөрчлийг арилгах хугацаатай үүрэг, даалгавар өгч, биелэлтийг хангуулна” гэж, 66 дугаар зүйлийн 66.1.3 дахь заалтад “иргэн, байгууллага, албан хаагчийн гомдол, мэдээллийн дагуу төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаанд шалгалт хийх, илэрсэн зөрчлийг арилгах хугацаатай шаардлага хүргүүлэх, хууль тогтоомж зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгох бүрэн эрхийг Зөвлөл хэрэгжүүлнэ” гэж тус тус заасны дагуу төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төрийн албаны тухай хуульд тус Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байхаар заасан<sup>2</sup> бөгөөд Зөвлөл 2022 онд 54 удаагийн хуралдаанаар төрийн албаны шинэтгэл, сайн засаглалын зарчмыг хэрэгжүүлэх, төрийн захиргааны болон хүний нөөцийн 389 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэн 670 тогтоол батлан гаргаж хэрэгжилтийг зохион байгуулан ажиллажээ.

Хэлэлцсэн асуудлыг тоон үзүүлэлтээр харахад албан тушаалын тодорхойлолт батлах зөвшөөрөл олгох эсэх 116, ерөнхий болон тусгай шалгалттай холбоотой асуудал 61, дүрэм журам, зөвлөмжийн төсөл 8, төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэвтэй холбоотой асуудал 4, маргаан хянан шалгах комиссын дүгнэлт 55, төрийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийсэн шалгалтын дүн 7,

<sup>2</sup> Төрийн албаны тухай хууль. 2017 он. 67.1 дэх заалт

салбар зөвлөлтэй холбоотой асуудал 57, зөвлөн туслах, хяналт шалгалт хийх ажлын хэсгийн тайлан 21, шагналтай холбоотой асуудал 4, бусад асуудал 56 байна.

Хувиар авч үзвэл маргаан хянан шалгах комиссын дүгнэлт 14.1 хувь, салбар зөвлөлтэй холбоотой асуудал 14.6 хувь, албан тушаалын тодорхойлолт хянаж батлах, зөвшөөрөл олгох асуудал 29.8 хувь, төрийн байгууллагын үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалттай холбоотой асуудал 1.7 хувийг эзэлж эдгээр нь нийт хэлэлцсэн асуудлын нийт 60.2 хувийг эзэлж байна.

Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын ирүүлсэн санал хүсэлт, өргөдөл гомдлыг Төрийн албаны зөвлөл хүлээн авч хууль журмын хүрээнд шийдвэрлэж, шаардлагатай зөвлөгөө, мэдээллийг өгч ажилласан байна.

Хууль тогтоомжийн дагуу баталсан удирдамж, чиглэлийн хүрээнд хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулахдаа хяналт, шалгалтын ажлын зарчим, зорилго, хүрээ, хяналт шалгалтын явцад баримтлах хууль тогтоомжийг тодорхой тусгаж, мэдээллийг урьдчилан хүргүүлж, ажлын тайланг хяналт шалгалт хийж буй холбогдох байгууллага, албан тушаалтанд тухай бүр танилцуулж, хяналт шалгалтын мөрөөр тухайн байгууллагаас гаргаж буй хууль зүйн үндэслэлтэй тайлбар, санал, хүсэлтийг тусгасны үндсэн дээр Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлүүлж ажилласан байна.

Тайлант хугацаанд Төрийн албаны зөвлөлийн болон Зөвлөлийн даргын шийдвэр, санаачилгаар 33 байгууллагын 791 албан хаагчийг төлөвлөгөөт хяналт, шалгалт иргэн байгууллага, албан хаагчийн гомдол мэдээллийн дагуу 25 байгууллагын 221 албан хаагчийг төлөвлөгөөт бус хяналт шалгалтад тус тус хамруулж, нийт 58 байгууллага, 1012 албан хаагчид холбогдох хяналт, шалгалтын үйл ажиллагаа зохион байгуулсан байна.

Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар Хяналт шалгалтын 18 ажлын хэсгийн тайланг хэлэлцэн шийдвэрлэж 193 иргэн, албан хаагчийг төрийн албаны тухай хууль тогтоомж зөрчиж төрийн жинхэнэ албан тушаалд томилсныг тогтоов. 175 албан хаагчид холбогдох “Зөрчил арилгах хугацаатай үүрэг, даалгавар” бүхий 30 тогтоолыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж ажиллажээ. Томилгооны зөрчил арилгах хугацаатай үүрэг даалгаврыг яамны 53, агентлагийн 80, нутгийн захиргааны байгууллагын 7, нийслэлийн дүүргийн 27, УИХ-аас удирдлага нь томилогддог байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан хаагч нарт тус тус хүргүүлсэн байна.

2022 онд Төрийн албаны зөвлөлийн 25 тогтоолыг биелүүлж, 132 албан хаагчид хамаарах зөрчлийг арилгасан бол тогтоол биелүүлэх хугацаа болоогүй 18 иргэн, албан хаагч байна.

Мөн томилгооны зөрчил арилгуулахаар хугацаатай үүрэг даалгавар бүхий 2021 онд хүргүүлсэн тогтоолыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй 31 иргэн, албан хаагчийн асуудлыг Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар дахин хэлэлцэж, томилсон шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэжээ.

Төрийн албаны тухай хууль тогтоомж зөрчсөн томилгоо нь бусдад давуу байдал олгосон зөрчил байгаа эсэхэд холбогдох хууль сахиулах байгууллагуудтай хамтран хяналт зохион байгуулж, илэрсэн зөрчилд тухай бүр хариуцлага тооцож,

арилгуулахын зэрэгцээ зөрчил давтагдахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөмж, мэдэгдэл, албан даалгавар өгч, биелэлтэд хяналт тавин ажилласан байна.

Цаашид төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаа, албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах зэрэг хүний нөөцийн томилгоотой холбоотой шийдвэр гаргах дүрэм, журмын хэрэгжилттэй холбоотой зарим зохицуулалт, холбогдох хууль тогтоомж, эрх зүйн орчинг боловсронгуй болгож уялдуулах зэрэг арга хэмжээ авах талаар холбогдох тайланд дурдсан байна.

***Төрийн албан хаагчийн ёс зүйг дээшлүүлж, төрийн албан дахь сахилга хариуцлагыг сайжруулах ажлын хүрээнд:***

Төрийн албаны тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэгт заасны дагуу төрийн албаны удирдах болон гүйцэтгэх албан хаагчид төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, мөрдөн хэрэгжүүлэхтэй холбогдсон зөвлөгөө өгөх, арга зүйн удирдлагаар хангах чиг үүргийг Төрийн албаны зөвлөл хэрэгжүүлдэг.

Төрийн албанд ёс зүй, сахилга хариуцлагын оновчтой тогтолцоо бүрдүүлэх, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх, төрийн албан хаагчдыг соён гэгээрүүлэх, болзошгүй зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих, сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор олон талын ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Улсын хэмжээнд 2022 оны жилийн эцсийн байдлаар төрийн 2961 байгууллагын дэргэд төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөл байгуулагдан ажиллаж байгаагаас 250 нь 2022 онд байгуулагдсан байна.

Тайлант хугацаанд 415 төрийн албан хаагч ёс зүйн зөрчил гаргаснаас төрийн захиргааны албан тушаалтан 221, төрийн үйлчилгээний албан тушаалтан 194 байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 0.1 хувиар буурсан үзүүлэлттэй гарсан байна. Ёс зүйн зөрчлийн тоо буурсан нь зэрэг үзүүлэлт боловч цаашид төрийн албан хаагчдын харилцаа, хандлага, ёс зүй, соёлд нөлөөллийн арга хэмжээг улам бүр нэмэгдүүлэх, үр дүнг дээшлүүлэх шаардлага байгааг илтгэж байна.

Ёс зүйн зөрчлийг шалгаж төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад зохих хариуцлага ногдуулсны 225 нь сануулах, 149 нь уучлал гуйхыг үүрэг болгосон хариуцлага хүлээлгэж, 11 тохиолдлыг ёс зүйн хариуцлага тооцох үндэслэлгүй гэж үзсэн байна.

2022 оны тухайд 6 яам, 5 агентлаг, 3 аймагт “Ёс зүйн зөвлөлийг бэхжүүлэх нь” дэд төслийг хэрэгжүүлэх замаар төслийн туршин нэвтрүүлэлтийн үр дүнг бэхжүүлэх, сургагч багш нарыг бэлтгэх, төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх суурь нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч ажилласны зэрэгцээ байгууллагуудын Ёс зүйн зөвлөлийн гишүүд харилцан туршлага хуваалцаж, байгууллагын соёл, төрийн албан хаагчийн ёс зүйтэй шийдвэр гаргахад нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд хэрэглэгдэх шинэ мэдлэг, ур чадвартай болгох 71 удаагийн сургалт, хэлэлцүүлэг, нөлөөллийн ажлыг зохион байгуулсан байна.

Байгууллагын соёлыг хэвшүүлэх, удирдлагын манлайлал ба байгууллагын алсын хараа, зорилгоо биелүүлэх шийдвэр гаргах чадварт сургах, чадавхжуулах зорилготой “Удирдлагын манлайлал ба байгууллагын соёл” сэдэвт сургалтыг УИХ-ын Ёс зүй, сахилга хариуцлагын хороотой хамтран зохион байгуулжээ. Сургалтад нийслэл, дүүргийн ЗДТГ, харьяа байгууллагууд, яамдын ТНБД, агентлагийн дарга, захирал зэрэг 212 удирдах ажилтныг оролцуулан зохион байгуулжээ.

Төрийн байгууллагууд төрийн албан хаагчийн ёс зүйн асуудалд ихээхэн анхаарч, төрийн албан хаагчийг соён гэгээрүүлэх сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг идэвхтэй зохион байгуулж 2022 онд 40845 албан хаагчийг хамруулжээ.

Төрийн албаны “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системд ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын модулийг хөгжүүлж, үйл ажиллагаанд оруулсан байна. Уг модуль нь төрийн байгууллагуудын ёс зүйн зөвлөл, түүний бүрэлдэхүүн болон ажлын төлөвлөгөө, тайлан, ёс зүйн гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлтийг бүртгэх бөгөөд ингэснээр ёс зүйн зөвлөл, түүний бүрэлдэхүүн, ёс зүйн зөвлөлийн төлөвлөгөө, тайлан, ёс зүйн гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлт, ёс зүйн зөрчил хүлээсэн албан хаагчдын талаар нэгдсэн мэдээллийн сантай болж төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, зөвлөгөө өгөх, арга зүйн удирдлагаар хангах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг судалгаанд суурилан явуулах нөхцөл бүрдэж байна.

Орон нутгийн захиргааны болон төрийн зарим байгууллагаас төрийн албан хаагчийн ёс зүй харилцаа хандлагыг анхаарал хандуулж, “Хандлагыг урамшуулъя”, “Ёс зүйтэй төрийн албан хаагч”, “Инээмсэглэл ТАХ-ийн ур чадварт нөлөөлөх нь”, “Зөв төрийн албан хаагч”, “Эерэг хандлага-эмчилгээний эхлэл”, “Зөв хандлага-эерэг нөлөө”, Стресс менежмент”, “Ёс зүйгээр үлгэрлэе”, “Хандлагаа өөрчилж-хамтдаа алхъя”, “Хувь хүний хөгжил манлайлал”, “Талархал” зэрэг аянуудыг санаачлан зохион байгуулжээ. Түүнчлэн Дорнод, Булган зэрэг аймгууд 2022 оныг “Ёс зүйг дээдлэх”, “Ёс зүйтэй-Мэдлэг чадвартай-Хариуцлагатай төрийн алба” -ны жил болгон ажилласан талаар холбогдох тайланд дурдсан байна.

**Хүний нөөцийн аудит хийх ажлын хүрээнд**, Төрийн байгууллагын үйл ажиллагаанд хийж буй хүний нөөцийн аудитад ёс зүйн асуудлыг нэг сэдэв болгон оруулж, аудитад хамрагдсан байгууллагын дэргэдэх ёс зүйн зөвлөл, түүний үйл ажиллагаа ямар байгаа талаар танилцаж, зөвлөмж чиглэлээр хангасан байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, харилцаа хандлагыг сургаж, соён гэгээрүүлж, байгууллагын ёс зүйн зөвлөл байгуулсан, журам, төлөвлөгөөг баталсан зэргээр ахиц ололт гарч байгаа талаар, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлийн ажиллах журмуудыг нэгтгэн анализ хийж үйл ажиллагааны дараалал харилцан

*....Манай байгууллагын Ёс зүйн зөвлөл яаралтай биш бол асуудал гарахаар хуралддаг. Нэг хурлаар 2 ба түүнээс дээш асуудлыг хэлэлцдэг. Иргэн бүртэй харилцдаг байгууллагын хувьд албан хаагч нартай холбоотой хандлага харилцааны зохисгүй байдал гаргасан, зөрчилтэй бүртгэл хийж хохирол учруулсан гэх мэт гомдол түлхүү байдаг.*

*...Ёс зүйн хорооны гишүүдийн хувьд гишүүн байлаа гээд элдэв нэмэлт цалин хөлс, урамшуулал тооцогддоггүй, харин ч хүний муу үзсэн нэр зүүх тохиолдол бий...*

**УБЕГ-ын Ёс зүйн хорооны гишүүнтэй хийсэн ярилцлагаас, 2023 он**

адилгүй, дүрэмд нийцээгүй дутагдалтай зүйлүүд байгаа талаар тус зөвлөлийн тайланд дурдагдсан байна.

Хууль тогтоомжийн шинэтгэлийн хүрээнд төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлийг бэхжүүлэх, үйл ажиллагаа явуулахад шаардлагатай төсөв хөрөнгийг шийдэх, ёс зүйн сургалт, мэдлэгийн үр нөлөөг гаргах зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлж ажилласан байна.

“Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системд төрийн албаны сахилга хариуцлагыг сайжруулах ажлын хүрээнд авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхээр ял шийтгүүлсэн төрийн албан хаагч болон шүүхийн шийтгэх тогтоолоор нийтийн албанд томилогдох эрх хасах ялаар шийтгүүлсэн иргэдийг “Хар жагсаалт”-д бүртгэн хөтөлж байна. Энэ жагсаалтыг гаргахдаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн гаргах ба жилийн эцсийн дүн мэдээнээс харахад 2019-2022 онд Шүүхийн шийтгэх тогтоолоор нийтийн албанд томилогдох эрх нь хасагдсан нийт 579 этгээд санд бүртгэгдсэнээс 227 нь эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж, гэм буруутай нь тогтоогдсон байна. Гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон төрийн албан хаагчдыг байсан төрийн албанаас чөлөөлүүлж, хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Төрийн албаны зөвлөлөөс төрийн албаны тухай хууль тогтоомж, чадахуйн зарчмын хэрэгжилтийн талаар төрийн байгууллагын үйл ажиллагаанд хүний нөөцийн аудит хийхээр Төрийн албаны тухай хуульд тусгагдсан нь төрийн албаны шинэтгэлийн нэг томоохон алхам болсон байна.

Хүний нөөцийн аудит нь бодит байдлыг үнэлж, зөвлөмж өгөх, арга зүйгээр хангаж хамтран ажиллах зорилготой. Төрийн албаны тухай хууль тогтоомж, чадахуйн зарчмын хэрэгжилтийн талаар төрийн байгууллагын үйл ажиллагаанд хүний нөөцийн аудит хийх нь манай улсын хувьд урьд өмнө байгаагүй шинэ чиг үүрэг бөгөөд төрийн байгууллагад хийж байгаа анхны хүний нөөцийн аудит болж байгаагаараа онцлогтой байна.

**Дүгнэлт:** *“Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх” чиг үүргийн хэрэгжилтийг төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээний дүн, төрийн албан хаагчийн ёс зүйг дээшлүүлж, төрийн албан дахь сахилга хариуцлагыг сайжруулах, хүний нөөцийн аудит хийх гэсэн 3 шалгуур үзүүлэлтийн хүрээнд авч үзээд 95% гэж дүгнэв.*

### **2.3. МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ**

Төрийн албаны тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэгт *“Томилох эрх бүхий этгээд болон төрийн албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн хооронд энэ хуулийн 25, 26, 27, 45, 46, 47, 48 дугаар зүйл, 52.2, 66.1.11-д заасан асуудлаар гарсан маргаан болон төрийн жинхэнэ албан хаагчаас цалин хөлс, ажиллах нөхцөл, баталгааны талаар гаргасан бусад маргааныг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол төрийн албаны төв байгууллага хянан шийдвэрлэнэ”* гэж, 76 дугаар зүйлийн 76.1 дэх хэсэгт *“Энэ хуулийн 75.1-д заасан төрийн албаны хүний нөөцийн удирдлага, мэргэшлийн шалгалттай холбогдон гаргасан шийдвэр хууль зүйн үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол төрийн албаны төв байгууллага*

*өөрчлөх буюу хүчингүй болгоно*” гэж заасны дагуу, Улсын Их Хурлын 2019 оны 20 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн албанд нэр дэвшигчийн эрх зөрчигдсөн тухай маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын хүрээнд ТАЗ 2022 онд төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн албанд нэр дэвшигчийн эрх зөрчигдсөн тухай маргааныг хянан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллажээ.

Тайлант хугацаанд 63 гомдолд маргаан үүсгэн шалгаж, маргаан хянан шалгах комисс томилон ажиллав. Томилох эрх бүхий этгээд, төрийн жинхэнэ албан хаагч хоорондын болон бусад асуудлаар гарах маргаан өмнөх оноос 27 маргаанаар буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь төрийн албан хаагчдын эрх зүйн мэдлэг дээшилж, тэдгээрийн зөрчигдсөн эрхийг хамгаалах зохицуулалт илүү боловсронгуй болж, иргэдийн Төрийн албаны зөвлөлд итгэх итгэл сайжирснаас гадна томилох, чөлөөлөх эрх бүхий албан тушаалтнууд Төрийн албаны зөвлөлийн зорилго, Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх идэвх сэргэсэнтэй холбоотой.

Маргаан хянан шийдвэрлэсэн Төрийн албаны зөвлөлийн шийдвэрийг холбогдох албан тушаалтан биелүүлээгүй тохиолдолд буруутай албан тушаалтныг үүрэгт ажлаас нь чөлөөлөх мэдэгдлийг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх харилцааг хуульчилсан нь маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг үр нөлөөг дээшлүүлж зөрчил давтагдахаас урьдчилан сэргийлэхэд түлхэц болсон байна.

Тайлант хугацаанд маргаан хянан шалгах комиссын 33 дүгнэлтийг Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж, эрх бүхий албан тушаалтны 23 шийдвэрийг Төрийн албаны тухай хууль тогтоомж болон төрийн жинхэнэ албан хаагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзэж, хүчингүй болгосны зэрэгцээ эрх бүхий албан тушаалтны 10 шийдвэр хууль зүйн үндэслэлтэй болохыг тогтоож шийдвэрлэсэн байна.

Маргаан хянан шалгах явцад зөрчил арилсан, шүүхэд хандсан, тухайн албан тушаалд гомдол гаргагч өөрөө Төрийн албаны тухай хууль, тогтоомж зөрчиж хууль бусаар томилогдсон нь тогтоогдсон, гомдлоосоо татгалзсан, харьяаллын бус маргаан болохыг тогтоож гомдол гаргагчид зохих хариуг хуулийн хугацаанд хүргүүлэх замаар маргаан бүхий 20 гомдлыг шийдвэрлэсэн байна.

Төрийн жинхэнэ албан хаагчийн эрх зөрчигдсөн маргаан нь томилох эрх бүхий албан тушаалтнуудын Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжийн талаарх мэдлэг хангалтгүй, хууль, журмыг зөв ойлгож хэрэглэх чадвар сул, албан хаагчийн гаргасан зөрчилд ногдуулах хариуцлагыг зөрчлийн шинж байдалтай нь уялдуулан хууль зүйн үндэслэл бүхий шийдвэр гаргаж чаддаггүй, мөн албан тушаалтны ёс зүй, хувийн ашиг сонирхлын зөрчил, улс төрийн намын нөлөөллөөс хамааралгүй болж чадаагүй зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой байна.

Зөвлөл иргэдийн гомдол, мэдээллээр болон өөрийн санаачилгаар хяналт шалгалт хийж илэрсэн зөрчлийг арилгуулдаг, төрийн албан хаагчийг хууль бусаар халдаг үзэгдлийг таслан зогсоодог, хууль зөрчигчийг эдийн засгийн хариуцлага хүлээлгэж төрд учирсан хохирлыг гаргуулдаг, Төрийн албаны зөвлөлийн болон шүүхийн шийдвэр биелүүлээгүй тохиолдолд буруутай албан тушаалтныг үүрэгт ажлаас нь чөлөөлөх мэдэгдлийг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх харилцааг хуульчилж, хариуцлага тооцдог, жишиг тогтоосноор зөрчил давтагдахаас



урьдчилан сэргийлж, Зөвлөлийн шийдвэрийг эрх бүхий албан тушаалтан заавал биелүүлдэг тогтолцоонд шилжсэн нь дэвшилттэй зүйл болсон байна.



Гомдол маргааныг хянан шийдвэрлэснээр төрийн жинхэнэ албан хаагчийн зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг сэргээж, 19 албан хаагчийг өмнө нь эрхэлж байсан албан тушаалд нь эргүүлэн томилуулж, 4 албан хаагчид ногдуулсан сахилгын шийтгэлийг хүчингүй болгосноос Зөвлөлийн 19 шийдвэрийг холбогдох эрх бүхий албан тушаалтан биелүүлсэн, 1 шийдвэрийг эс зөвшөөрч шүүхэд хандсан, 3 шийдвэрийг биелүүлээгүй байна. Төрийн албан хаагчийн эрх зөрчигдсөн маргааныг хянан шийдвэрлэхдээ цаашид анхаарах, авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодотгон гаргасан байна.

***Төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах, төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд***

Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлд заасан төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж, тайлант хугацаанд төрд учруулсан 303 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлэх шаардлагыг хууль бус шийдвэр гаргасан буруутай 27 албан тушаалтанд хүргүүлж, уг шаардлагыг биелүүлээгүй 7 албан тушаалтанд холбогдох 107 сая төгрөгийг нөхөн төлүүлэх нэхэмжлэлийг харьяаллын дагуу холбогдох шатны шүүхэд гаргасан байна.

Шүүхээр 13 нэхэмжлэл хянан шийдвэрлэгдэж төрд учруулсан 145.7 сая төгрөгийн хохирлыг хууль бус шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болж, бусад нэхэмжлэл шүүхийн шатанд хянагдаж байна. Шүүхийн шийдвэрийн дагуу 39.5 сая төгрөгийг буруутай албан тушаалтан нөхөн төлж, төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн дүнтэй байна.

Иргэний хэргийн шүүхээр 13 хэрэг эцэслэн хянан шийдвэрлэгдэж, төрд учруулсан 145.7 төгрөгийн хохирлыг хууль бус шийдвэр гаргаж, төрд хохирол учруулсан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болж, Төрийн албаны зөвлөл болон шүүхийн шийдвэрийн дагуу 39.5 төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн байна.

Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2 дахь хэсэгт “Төрийн албаны төв байгууллага шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй



тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргана” гэж заасны дагуу шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэлийг 2019, 2020, 2021 онд гарсан төрийн жинхэнэ албан хаагчийн хүний нөөцийн томилгоотой холбоотой шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэлийг хөтлөн ажилласан байна.

Төрийн албаны зөвлөлийн хэрэгжүүлсэн тус ажлын үр нөлөөгөөр төрийн жинхэнэ албан тушаалд иргэн, албан хаагчийг хууль бусаар томилдоггүй, төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар чөлөөлөх зөрчил мэдэгдэхүйц багассан байна. Мөн томилох эрх бүхий албан тушаалтан хууль хэрэглээний мэдлэгтэй болж, хууль бус шийдвэрээс урьдчилан сэргийлэх, зөвлөгөө авах зэргээр эрсдэлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж ажиллаж эхэлсэн талаар дэвшилттэй сайн талууд гарсан байна.

***ДҮГНЭЛТ: “Маргаан хянан шийдвэрлэх” чиг үүргийн хэрэгжилтийг Төрийн албаны тухай хуулийн 75 дугаар зүйлд заасан маргааныг хянан шийдвэрлэх; Маргаан хянан шийдвэрлэсэн Зөвлөлийн шийдвэрийг биелүүлэх талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд хугацаатай үүрэг даалгавар өгөх, биелэлтийг хангуулах; төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах гэсэн 3 шалгуур үзүүлэлтийн хүрээнд үзэж, хэрэгжилтийг 95% гэж дүгнэв.***

#### **2.4. СУРГАЛТ СУДАЛГАА ЗОХИОН БАЙГУУЛАХ, МЭДЭЭЛЛИЙН САН ЭРХЛЭХ**


Төрийн албаны зөвлөл 2022 онд үйл ажиллагаандаа цахим хэрэглээг нэвтрүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай, нээлттэй, хүртээмжтэй хүргэх чиглэлээр дорвитой ахиц гаргаж, төрийн байгууллагуудад манлайлал үзүүлж ажилласан байна.

Мэдээллийн технологи, инновацад суурилсан цахим хэрэглээг нэвтрүүлэх нь төрийн албаны шударга, ил тод, хариуцлагатай байдлыг хангах, хүнд суртал, чирэгдлийг арилгах, төрийн байгууллага болон төрийн албан хаагчид, иргэдийг төрийн албаны талаар иж бүрэн мэдээллээр хангах, төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, дүн шинжилгээ хийх, тайлан мэдээг бодит байдалд тулгуурлан гаргах, судалгаа, баримт нотолгоонд суурилсан шийдвэр гаргах, нээлттэй, ил тод төрийн албыг бэхжүүлэх үндэс суурь болно.

*Мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, мэдээллээр хангах талаар авсан томоохон арга хэмжээг тоймлон үзвэл:*

**Төрийн албаны хүний нөөцийн мэдээллийн их өгөгдөл, цахимжуулалт**

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт“ Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжүүлэх ...” зорилтыг дэвшүүлсэн.



Орчин үеийн мэдээллийн технологийн хөгжилд тулгуурлаж Төрийн байгууллагууд өөрийн үйл ажиллагаагаа цахимжуулснаар салбар бүрт олон тооны мэдээллийн сан бий болж байна. Эдгээр сангийн мэдээллийг төрийн албанд ашиглах, интеграци хийж нэгтгэх шийдлийг тодорхойлон “Төрийн их өгөгдөл”-ийг бий болгохоор ажиллаж байна.

Төрийн их өгөгдлийн нэг хэсэг болох төрийн албан хаагчийн бүртгэл, мэдээллийн санг бий болгох зорилтыг тавин, хүчин чармайлт гарган ажилласны үр дүнд төрийн албаны “Цахим мэдээллийн нэгдсэн сан, дэд бүтэц бий болгох” үйл явцад ахиц дэвшил гарч байна.

• **Төрийн албаны хүний нөөцийн цахим системийн интеграци**

2022 онд Төрийн албаны “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим систем нь “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн цахим систем”, “E-Mongolia”, Улсын бүртгэлийн цахим мэдээллийн сангийн систем, Боловсролын мэдээллийн технологийн төвийн “Боловсролын мэдээллийн систем”-тэй холбогдож хуулийн этгээд, иргэний бүртгэлийн мэдээлэл, нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, ерөнхий боловсролын болон дээд боловсролын талаарх мэдээллийг холбогдох төрийн байгууллагуудаас “ХУР” системээр дамжуулан авах, шаардлагатай мэдээллийг өгөх интеграцийг боловсруулан, бүрэн ашиглалтад оруулсан.

Сангийн яамны “Төрийн байгууллагуудын цалингийн нэгдсэн систем”-ийг “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системтэй холбон мэдээлэл солилцох болсноор цалингийн сан түүний хяналт, төрийн албаны цалингийн мэдээллийн аюулгүй байдалд хяналт тавих, ижил төрлийн мэдээллийг нэг эх үүсвэрээс ашиглах, төрийн албан хаагчийн орон тооны нарийвчилсан мэдээ авч, хяналт хийх, төлөвлөлт хийх, төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж шаардлагатай мэдээллээр хангах, төлбөр тооцооны хялбар аюулгүй байдлыг хангах, тайлан мэдээ гаргах, төрийн албан хаагчдын цалингийн мэдээллийн санг нэгтгэх, улсын хэмжээнд цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмж хангамжийн зардлуудын төлөвлөгөө болон одоогийн зарцуулалтын хэмжээг хянах, цалингийн тооцооллын удирдлагыг иж бүрнээр боловсруулах боломжтой болсон байна.

Мэдээллийн систем хооронд өгөгдөл солилцох интеграцийг хөгжүүлснээр цахим орчинд байгаа бүрэн, үнэн зөв мэдээллийг иргэн, төрийн албан хаагчаас дахин шаардахгүй, нотариатаар гэрчлүүлэх шаардлагагүй болж цаг хугацаа, эдийн засгийн хэмнэлт бий болохоос гадна Төрийн алба, төрийн албан хаагчидтай холбоотой үнэн зөв, давхардал, зөрүүгүй статистик тоон мэдээлэлд суурилсан бодлого, шийдвэр гаргах бололцоо улам бүр өргөжих юм.

- **Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо**

Төрийн албаны зөвлөл төрийн албан хаагчдын улсын нэгдсэн тоо бүртгэлийг хөтлөх, тайлан мэдээ гаргах ажлыг 1995 оноос хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд механик ажил, цаг хугацаа, хүний оролцоо ихээр шаарддаг тус ажлыг мэдээллийн технологид тулгуурлан шат дараатай шинэчлэн хөгжүүлж байна.

“Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, мэдээлэл авах журам”-ын хүрээнд “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системийг бий болгон хөгжүүлж байгаа бөгөөд уг системийн суурь судалгааг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн санхүүжилтээр хийж, үйл ажиллагааг явуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Судалгааны үндсэн дээр 12 модуль бүхий иж бүрэн системийг хөгжүүлэх бөгөөд 2022 онд “Албан тушаалын тодорхойлолтын систем”, “Ёс зүйн зөрчил, хяналт мэдээлэл”, “Сургалт”, гэсэн бие даасан нийт 3 модулийг нэмж хөгжүүлэн хэрэглээнд оруулсан байна.

- **Албан тушаалын тодорхойлолтын систем**

Албан тушаалын тодорхойлолт нь төрийн байгууллагын бүтэц, орон тоонд хяналт тавих, төлөвлөлт, тайлагналтын цахим тогтолцоог бүрдүүлэх суурь болох тул түүнийг цахимжуулах шийдлийг тодорхойлон, боловсруулалт хөгжүүлэлтийг хийж төрийн захиргааны албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах, хянах, батлах зөвшөөрөл олгох ажлыг Төрийн албаны тухай хууль, холбогдох журамд нийцүүлэн бүрэн цахимжуулж, үйл ажиллагаанд нэвтрүүлжээ.

Энэхүү цахим систем нэвтрэхээс өмнө давхардсан тоогоор төрийн захиргааны албаны 24000 гаруй албан тушаалын тодорхойлолтод батлах зөвшөөрөл олгосон бөгөөд албан тушаалын тодорхойлолтын бүртгэлийн цахим сангийн системийг нэвтрүүлснээр албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулах, шинэчлэн сайжруулах, хянах ажиллагааг хялбаршуулах, төрийн байгууллага, албан тушаалтны чадавх, оролцоог нэмэгдүүлэх, Төрийн албаны бүтээмж нэмэгдэх, зардал хэмнэгдэх нөхцөл бүрдсэн байна.

- **“Ёс зүйн зөрчил, хяналт мэдээлэл” модуль**

Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилт, ёс зүйн болон сахилгын зөрчлийн талаарх нэгдсэн бүртгэлийг бий болгохын зэрэгцээ төрийн байгууллагуудын ёс зүйн зөвлөлөөс ёс зүйн зөрчлийн шийдвэрлэлтийн байдал, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилт, зөрчлийн талаарх судалгаа шинжилгээ хийх, дүгнэлт, санал боловсруулах, зөвлөгөө, удирдлага арга

зүйгээр хангах боломжийг бүрдүүлсэн “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системийн “Ёс зүйн зөрчил, түүний хяналт” модулийг 2022 онд хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн. Энэ нь төрийн албанд ёс зүй, сахилга хариуцлагын оновчтой тогтолцоог бүрдүүлж, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Төрийн жинхэнэ албан тушаалд шатлан дэвшүүлэх буюу мерит зарчмыг хэрэгжүүлэх бодитой нөхцөлийг бүрдүүлж, тусгай шаардлага хангасан төрийн албан хаагч бүрийг мэргэшүүлэх багц сургалтад хамруулах зорилгоор “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системийн “Сургалт”-ын модулийг 2022 онд нэмэлтээр хөгжүүлж хэрэглээнд нэвтрүүллээ. Энэ системийг нэвтрүүлснээр төрийн албан хаагчийн сургалтын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, төрийн байгууллагын төсөвт албан хаагчийн сургалтын зардлыг төрийн байгууллага бүрээр төсөвт тусгадаг болох, сургалтын квотыг шударгаар хуваарилах, хуульд заасан тусгай шаардлагыг бүрэн хангасан албан хаагчийг мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах хүртээмжийг нэмэгдүүлэх, тайлан мэдээллийг илүү нарийвчлалтай гаргах боломжийг бүрдүүлсэн олон талын ач холбогдолтой юм.

- **“Цахим хувийн хэрэг”**

Монгол Улсын Их Хурлаас Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Цахим гарын үсгийн тухай зэрэг хуулиуд батлагдсантай холбогдуулан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ыг Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 600 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ыг, 2 дугаар хавсралтаар “Төрийн албан хаагчийн анкет”-ын маягтыг, 3 дугаар хавсралтаар “Танилцуулга”-ын маягтыг, 4 дүгээр хавсралтаар “Албан тушаалын карт”-ын маягтыг тус тус шинэчлэн баталж, “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системтэй уялдсан цахим хувийн хэрэгтэй болох нөхцөлийг бүрдүүлсэн байна.

- **Төрийн албаны хүний нөөцийн сонгон шалгаруулалтын цахимжуулалт**

Төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалт /тухайн албан тушаалын/-ыг төрийн албаны төв байгууллага зохион байгуулахаар хуульчилсан бөгөөд 2021 оноос сонгон шалгаруулалтын бүхий үйл ажиллагааг бүрэн цахимжуулж эхэлсэн нь шинэтгэлийн гол үр дүнгийн нэг бөгөөд чадахуйн зарчмын хэрэгжилтийг хангах, хөндлөнгийн нөлөөллөөс ангид, олон нийт, мэргэжлийн байгууллагуудын хяналтын дор ил тод, нээлттэй явуулах баталгааг хангасан гэж үзэж байна.

Төрийн албаны тухай хуульд зааснаар Засгийн газар төрийн албаны хөгжлийн бодлого, төлөвлөлтөд нийцүүлэн төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхээр, Төрийн албаны зөвлөл төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавихаар хуульчилсан бөгөөд Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, төрийн албаны шинэтгэлийн хүрээнд төрийн хүний нөөцийн бодлого, ажиллах орчин нөхцөл, цалин хөлс, нийгмийн баталгааны талаар хэрэгжүүлж буй хөтөлбөр, үйл ажиллагааг оновчтой тогтоож, хэрэгжүүлэх чиглэлийг Төрийн албаны зөвлөл баримтлан ажиллаж, төрийн байгууллагууд албан

хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрүүдийг батлан хэрэгжүүлж байна.

Төрийн албан хаагчийн цалин хөлс нь төрийн албаны хүний нөөцийн тогтвортой бодлогыг хэрэгжүүлэх үндсэн хүчин зүйлийн нэг бөгөөд Төрийн албаны зөвлөл бүрэн эрхийнхээ хүрээнд Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохистой түвшинд байнга хангуулахын тулд зөвлөмж, арга зүйгээр хангах, хэрэгжилтэд хяналт тавих, сургалт нөлөөллийн үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх зэрэг шат дараатай, харилцан уялдаа бүхий арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

### ***Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны давтан сургалт***

Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх багц сургалтын агуулга, хөтөлбөрийг албан тушаалын онцлог, хариуцан гүйцэтгэх чиг үүргийг харгалзан боловсруулан хэрэгжүүлж, сургалтыг Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллага болох Удирдлагын академи хариуцан хэрэгжүүлж байна.

Төрийн албаны мэргэшүүлэх багц сургалт болон дунд хугацааны давтан, чиглүүлэх богино хугацааны сургалтын мэдээлэл /2021-2022/

д/д	Сургалтын төрөл	Он		Хамрагдсан ажилтны тоот
		2021	2022	
1	Тэргүүн түшмэлийн албан тушаалын сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	36	53	232
2	Эрхэлсэн түшмэлийн албан тушаалын сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	178	282	1286
3	Ахлах түшмэлийн албан тушаалын сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	403	806	4016
4	Чиглүүлэх болон богино хугацааны сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	4672	7212	13579
5	Мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	622	546	1738
6	Мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	608	421	1502
<b>Нийт</b>		<b>6519</b>	<b>9320</b>	<b>22353</b>

Тайлант хугацаанд албан тушаалын сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо өссөн бөгөөд нийт 9320 албан хаагч төрийн албан хаагчийг мэргэшүүлэх 6 төрлийн сургалтад хамрагдсан ба үүнээс Мэргэшүүлэх багц сургалтад 1141 албан хаагч, чиглүүлэх болон богино хугацааны сургалтад хамрагдсан байна.

### ***Төрийн албан хаагчдад зориулсан арга зүйн сургалт***

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төсөлтэй хамтран төрийн албаны үнэт зүйл, ёс зүй, манлайлал, Төрийн албан хаагчийн тангараг өргөх ёслол, Залуу төрийн албан хаагчдын менторшип хөтөлбөр, Сэтгэлгээний өөрчлөлтийн шинэлэг арга хэрэгслүүд, Эмэгтэйчүүдийн манлайлал зэрэг сэдвийн хүрээнд 10 яам, 33 агентлаг, 4 аймагт нийт 9371 төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулсан байна.

Төрийн албаны хууль тогтоомж, чадахуйн зарчмын хэрэгжилтийг хангахад учирч буй хүндрэл бэрхшээл, түүнийг даван туулах арга зам болон хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлтийг тайлбарлан таниулах сургалтыг хяналт шалгалтын явцад 58 байгууллага, 1012 албан хаагчид, аудит хийсэн 52 байгууллагын 1130 албан хаагчдад “Төрийн албаны тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт, дагалдан гарах журмууд, холбогдох бусад асуудлаар сургалт зохион байгуулжээ.

### **Төрийн албаны зөвлөлийн “брэнд” “7:4:10” арга зүйн сургалт**

Цар тахлын хүндрэлийг даван туулах, төрийн бүтээмж, төрийн албан хаагчдын ёс зүй, цогц ур чадварыг дэмжих, шинэ мэдлэг, мэдээлэл түгээхэд чиглэгдсэн “7:4:10” арга зүйн вэбинар сургалтыг долоо хоног бүр уламжлал болгон зохион байгуулж байна.

2022 онд 6 багц сэдвээр уг сургалтыг 32 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 92335 хэрэглэгчийн эрхээр 150000 гаруй албан хаагчийг хамруулсан байна. Сургалтын видео бичлэгүүдийг Төрийн албаны зөвлөлийн [www.csc.gov.mn](http://www.csc.gov.mn) цахим хуудаст цахим сан үүсгэн байршуулсан тул хэдийд ч үзэж, ашиглах боломжтой юм байна. Энэхүү сургалтаар төрийн албаны шинэтгэлийн бодлого, төрийн онол, чиг хандлага, судалгаа шинжилгээ, байгууллагын бүтээмж, хувь хүний хөгжлийг дэмжих, шинээр баталсан хууль эрх зүйн зохицуулалт, хөдөлмөрийн харилцаа ба хүний эрхийн асуудал, олон улсын туршлага, Монгол улсын дипломат бодлого, гадаад харилцаа, мэдээллийн аюулгүй байдал зэрэг өргөн сэдвүүдээр онол, арга зүй, танин мэдэхүйн мэдлэг мэдээллийг улс төр, нийгмийн зүтгэлтэн, эрдэмтэн багш, судлаачид орон даяар нэгэн зэрэг түгээж байна.



2023 онд төрийн бүтээмжийг дэмжихэд чиглэсэн байгууллага, хувь хүний нийгэм, сэтгэл зүйн болон олон улсын байгууллагын туршлагад үндэслэсэн цаг үеийн асуудал зэрэг агуулгын хүрээнд сургалтыг явуулахаар зорьж байна.

### **Төрийн албаны судалгаа, шинжилгээний ажлыг зохион байгуулах**

Төрийн албаны дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, менежментийн онолын шилдэг бүтээлүүдтэй танилцуулах, шинэ мэдлэг, мэдээлэл түгээн дэлгэрүүлэх чиглэлээр олон ажлыг санаачлан хэрэгжүүлж, төрийн албаны шинэтгэлийг системтэй, оновчтой, зөв хэрэгжүүлэхэд судалгаанд суурилсан, шинжлэх ухаанч арга зүй, бодлого, үйл ажиллагааг өргөжүүлэх, нэвтрүүлэхэд анхааран ажиллажээ.

Төрийн албатай холбоотой судалгаа, шинжилгээний ажлыг зохион байгуулахдаа суурь болон хавсарга, тойм судалгаануудыг олон чиглэлээр төлөвлөн судалгааны үр дүнг нийтийн хүртээл болгох, судалгаанд суурилсан зөв бодлого шийдвэр гаргахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажилласан байна.

Төрийн албаны чиглэлээр 2003-2022 онд эрдэмтэн судлаачдын хийсэн 47 судалгааны бүтээлийн катологи үүсгэн Төрийн албаны зөвлөлийн [www.csc.gov.mn](http://www.csc.gov.mn) цахим хуудсанд байршуулан олон нийтийг мэдээллээр хангах, судалгааны бүтээлийг ашиглах боломжийг бүрдүүлсэн. Түүнчлэн жил бүр тус зөвлөлөөс эрхлэн гаргаж, нийтэд түгээдэг “Төрийн албан хаагчийн нэгдсэн тоо бүртгэл” нь төрийн албаны шинэтгэл, түүний үр дүн, үр нөлөөний талаар сонирхон судалдаг эрдэмтэн судлаач, мэргэжилтэн, төрийн албан хаагчдын мэдлэг, мэдээллийн чухал эх сурвалж болж хэвшсэн байна.

*...Төрийн үйлчилгээнүүдийг цахимжуулаад байхад л төрийн албан хаагчийн тоо буурахгүй харин ч эсрэгээрээ өсөх хандлагатай байх юм, учир юунд байна вэ?...*

*...Хүн амын өсөлт, суурьшлын бүс нэмэгдэхийн хэрээр тэнд төрийн үйлчилгээг хүргэх ёстой. Ингэхээр цэцэрлэг, сургуулийн багш, эмнэлэг, цагдаа, хорооны ажилтан гэх мэт төрийн албан хаагчдыг ажиллуулах шаардлага гарна...*

*... Төрийн албанд эмч, багш гэх мэт төрийн үйлчилгээний албан хаагч 67,6%, цэрэг цагдаа гэх мэт төрийн тусгай албан хаагчдын эзлэх хувь 20,9% буюу дийлэнх хувийг эзэлж байгаа бол төрийн захиргааны албан хаагч эзлэх хувь 9,8% байна...*

*...Төрийн үйлчилгээг цахимжуулж байгаа болов ч тэр цахимжуулсан үйлчилгээний ард олон төрийн байгууллага, албан хаагч нар ажиллаж илүү их цаг, хүч, санхүүгийн зардлыг гаргах болдог гэдгийг ойлгох хэрэгтэй....*

**ТАЗ-ийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас, 2023 он**

#### Судалгааны иж бүрэн томоохон ажлыг тоймлон үзүүлбэл:

- 2022 онд төрийн албаны талаар дараах чиглэлийн судалгааг эрдэмтэн судлаачдад захиалж болон төрийн албаны “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим систем”-ийн мэдээлэлд тулгуурлан гүйцэтгүүлсэн байна.
- “Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааны хэрэгжилт, төлөв байдал”-ыг Удирдлагын академийн эрдэмтэн судлаачид судалж, судалгааны тайланг гаргасан.

Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуулиар сонгогдсон төлөөлөгчдийн тоо нь хуулиар заасан хувь хэмжээтэй тохирч байгаа эсэх, төлөөлөгчид нь төрийн захиргааны албыг давхар эрхэлж байгаа эсэхийг тодруулах, дүн шинжилгээ хийх зорилгоор судалгаа хийв. Энэ судалгааг хийснээр бүх шатны ИТХ-ын насны бүлэг, хүйс, боловсролын түвшин, төлөөлөгчөөр сонгогдсон тоо, улсад ажилласан жил, одоогийн эрхэлж байгаа зэрэг бүхий өгөгдөл, мэдээллийг бий болгох суурь судалгааны мэдээллийг бүрдүүлэх, уг тоон мэдээлэлд тулгуурлан анализ дүгнэлт хийх ач холбогдолтой болсон байна.

- Дэлхийн банкны зөвлөхүүдтэй хамтран “төрийн захиргааны албан хаагчдын үндсэн цалин, нэмэгдэл, гүйцэтгэлд суурилсан цалингийн тогтолцоог боловсронгуй болгох” судалгаа

**Дүгнэлт:** “Сургалт, судалгаа зохион байгуулах, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх” чиг үүргийн хэрэгжилтийг Төрийн албан хаагчийн хувийн хэрэг, тоо бүртгэлийн нэгдсэн мэдээллийн сан болон бусад санг бүрдүүлэх, төрийн алба, албан хаагчтай холбоотой мэдээллээр хангах; Төрийн жинхэнэ албан тушаалтныг мэргэшүүлэх багц сургалт, албан тушаалын ажлын байран дахь сургалтын агуулга, хөтөлбөрийн талаар санал боловсруулах; Төрийн албаны судалгаа, шинжилгээний ажлыг зохион байгуулах гэсэн 3 шалгуур үзүүлэлтийн хүрээнд үзэж, хэрэгжилтийг 100% гэж дүгнэв.

## **2.5.МЭРГЭШИЛ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ**

**Төрийн байгууллагын чиг үүргийн шинжилгээ хийхэд мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгөх ажлын хүрээнд,** Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төслийг боловсруулах, зохицуулах харилцаа, төрийн байгууллагын ёс зүйн зөвлөлийн эрх зүйн зохицуулалт болон бусад асуудлаар Төрийн албаны зөвлөл зохих дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Тухайлбал: Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороотой хамтран Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төслийн уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, Монгол Улсын Их Хурал, яам, агентлаг, УИХ-аас удирдлага нь томилогддог байгууллагын удирдлага, төрийн албан хаагчдын төлөөлөл, эрдэмтэн судлаачид оролцож хуулийн төслийн нэр томъёо, зохицуулах харилцаа, ёс зүйн зөвлөлийн эрх зүйн зохицуулалт зэрэг асуудлын хүрээнд илтгэл хэлэлцүүлэн, санал солилцож, байр сууриа илэрхийлж, саналаа нэгтгэжээ.

Цар тахлын дараах төрийн албаны хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах журам, аргачлал, мэргэшил, арга зүйн зөвлөгөөг тухай бүр гарган хүргэж ажилласан байна. Тухайлбал:Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журмыг шинэчлэн баталж, төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжих, сэлгэн ажиллах, цар тахлын үед төрийн албан хаагч, иргэний ажилласан хугацааг тооцох, 2019 оны нэгдүгээр сарын 01-ний өдрөөс өмнө хууль ёсны дагуу төрийн албанд томилогдсон албан хаагчид албан тушаалын тодорхойлолтын шинэ шаардлагад хамаарах эсэх асуудлыг төрийн албаны хэмжээнд нэг мөр хэрэгжүүлэх зөвлөмж гаргав.

Монгол Улсын Их Хурлын байнгын хороо, зарим гишүүдийг Ковидын үеийн төрийн алба, төрийн албаны томилгоо, албан хаагчдын ажиллах нөхцөл, баталгаа, хуулийн хэрэгжилтийн талаарх мэдээллээр тухай бүр хангаж ажилласан байна.

“Цогц чадамж”-д суурилсан олон улсын жишиг болсон ярилцлагын S.T.A.R /Situation-нөхцөл байдал, Task-даалгавар, Action-үйлдэл, Result-үр дүн/ аргыг төрийн албаны тусгай шалгалтад нэвтрүүлж эхлээд байна. Тухайлбал:НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Монгол Улсад мэргэжлийн иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төсөлтэй хамтран ярилцлагын шалгалтын үед дээрх ярилцлагын үед ажил горилогчийн ур чадварыг илрүүлэх мэдлэг, ур чадварыг олгох сургалтыг зохион байгуулж Салбар зөвлөлийн нийт 197 гишүүн хамрагдсан байна.

Төрийн албаны зөвлөл төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагааг шинэ шатанд гаргах, төгөлдөржүүлэх хүрээнд Канад Улсын Засгийн газрын дэмжлэгтэй “Мерит” төсөлтэй хамтран “Ур чадварт суурилсан хүний



нөөцийн бүрдүүлэлт, зан төлөвт суурилсан сонгон шалгаруулалт” сэдвээр сургалт зохион байгуулсан.

Төрийн албаны сонгон шалгаруулалтын цахим системийн найдвартай ажиллагааг бусад байгууллагууд хүлээн зөвшөөрч үйл ажиллагаандаа ашиглаж, хамтран ажиллаж эхэллээ. Тухайлбал: “Эрдэнэс монгол” Төрийн өмчит үйлдвэрийн газрын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын бүртгэл болон цахим системд оруулсан шалгалтын сорил даалгавраар шалгалтыг амжилттай зохион байгуулжээ.

Чадахуйн зарчмын хэрэгжилтийг хангах суурь нөхцөл болсон төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлж, хянаж батлах зөвшөөрөл олгох, түүний хэрэгжилтэд хяналт тавих үүргийг хэрэгжүүлэн ажилласан. Өнгөрсөн жилүүдэд төрийн захиргааны нийт албан хаагчид хамаарах 24589 албан тушаалын тодорхойлолтыг хянан хэлэлцэж, томилох эрх бүхий албан тушаалтанд батлах зөвшөөрөл олгосон байна.

2022 онд 10 яам, 8 агентлаг, 22 нутгийн захиргааны, бусад 4 байгууллагын удирдах гүйцэтгэх 1077 албан тушаалын тодорхойлолтыг шинээр, 861 албан тушаалын тодорхойлолтыг шинэчилж, 217 өөрчлөлт оруулан Төрийн захиргааны албан тушаалын нийт 2155 албан тушаалын тодорхойлолтыг батлах зөвшөөрөл олгосон байна. Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх, төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулах тусгай шалгалтыг цахим технологи ашиглан, хараат бус, ил тод, шударга явуулах нөхцөл хангаж, шалгалтын агуулга, аргачлал, зохион байгуулалт, арга хэлбэрийн томоохон шинэчлэл хийгдэж байна. Тухайлбал: Төрийн албаны шалгалтад бэлтгэх, мэдлэг олгох, мэдээлэл түгээх олон талт зорилготой гар утасны аппликейшнийг олон нийтийн хэрэглээнд нэвтрүүлж үнэ төлбөргүйгээр аппстор, плейстор дээр байгууллагын албан ёсны хаяг үүсгэн шилжүүлэн байршуулсан байна.

2022 онд Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүдийн ахалсан зөвлөн туслах ажлын хэсэг Архангай, Баян-Өлгий, Булган, Дархан-Уул, Завхан, Орхон, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд аймаг, зарим сумдын Засаг даргын Тамгын газарт ажиллаж, Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж төрийн албан хаагчидтай уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулан Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, шинэтгэлийг эрчимжүүлэх талаар үүрэг чиглэл өгөх, зөвлөн туслах, санал хүсэлтийг нь сонсох, сургалт зохион байгуулах, Төрийн албаны шалгалтын бэлтгэл ажил, явцтай газар дээр нь танилцаж зөвлөгөө мэдээлэл өгөх зэрэг ажлыг зохион байгуулжээ.

Төрийн албаны хууль тогтоомж, шинэтгэлийн үйл явцыг бүх шатанд жигд хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах, бүрэлдэхүүнийг төрийн албаны мэргэшсэн, тогтвортой албан хаагчдаар бүрдүүлж үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахад анхаарч яам, агентлаг, аймаг, нийслэлийн нийт 52 Салбар

зөвлөлийг мэргэшил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангаж, хамтран ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд орон нутгийн төрийн байгууллагын хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг хангах, төрийн үйлчилгээг иргэдэд зөв, шуурхай хүргэх болон Төрийн албаны тухай хууль, шинэтгэлийн бодлого, стратеги, чадахуйн зарчим, шатлан дэвшүүлэх тогтолцоо, хүний нөөцийн бодлого, үйл ажиллагааны талаар сургалт, сурталчилгаа хийж, мэргэшил арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан байна.

**Дүгнэлт: “Мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгөх” чиг үүргийн хэрэгжилтийг төрийн байгууллагын чиг үүргийн шинжилгээ хийхэд мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгөх гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд үзэж 100% гэж дүгнэлээ.**

### БҮЛЭГ 3. ТӨРИЙН АЛБАНЫ ШИНЭТГЭЛТЭЙ ХОЛБОГДСОН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ



Хууль тогтоох байгууллагаас Төрийн албаны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж төрийн албаны ангилал хооронд ур чадварын шилжилт хийх эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна. Тухайлбал Төрийн тусгай албан тушаалыг төрийн захиргааны албан тушаалын ангилалд

адилтган авч үзэх албан тушаалын жагсаалт, төрийн үйлчилгээний удирдах албан тушаалыг төрийн захиргааны албан тушаалын ангилалд адилтган авч үзэх албан тушаалын жагсаалтыг Засгийн газрын саналыг үндэслэн төрийн албаны төв байгууллага батлахаар заасан. Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасан буюу төрийн улс төрийн албан тушаалд ажилласан хугацааг төрийн захиргааны албан тушаалын зохих ангилалд ажилласан хугацаанд дүйцүүлэн тооцож болох уг хугацааг төрийн захиргааны албан тушаалын ангилалд хамаарах алба тушаалд ажилласан хугацаанд дүйцүүлэн тооцох журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батлахаар хуулийн нэмэлт өөрчлөлтөөр зохицуулсан байна. Төрийн албаны тухай хуулийн эдгээр зохицуулалтыг хэрэгжүүлэх журам, жагсаалт батлагдсан ба энэхүү зохицуулалт хэрэгжсэнээр төрийн захиргааны албан тушаалд ажиллах нөөц, ур чадварын өрсөлдөөн, шилжилт, салбар хоорондын албан хаагчдын хөдөлгөөн, томилгоо, сул орон тооны нөхөн хангалтад дэмжлэг болох юм.

Ур чадварын бүтээмжийн шилжилтийг нэвтрүүлснээр төрийн албаны шалгалтаар хувь хүний зан төлөв, цогц ур чадварыг үнэлэх, чадахуйн зарчмыг хэрэгжүүлэх арга зүйн дэмжлэгийг бодитойгоор нэмэгдүүлэх боломжтой болсон байна.

Төрийн албаны ангилал, зэрэглэл, цалин хөлс, нэмэгдлийн талаар бодлогын санал гаргаснаас гадна төрийн албаны шинэтгэл, хүний нөөцийн бодлогын баримт бичгийн төслийг боловсруулсан байна.

Хариуцлагатай, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлэх ажлын хүрээнд хууль тогтоомж зөрчиж томилогдсон 1472 албан тушаалтныг томилсон шийдвэрийг хүчингүй болгох, төрийн жинхэнэ албан тушаалтанд холбогдох төрд учруулсан хохирлын нэгдсэн бүртгэлийг хөтөлж, төрийг хохиролгүй болгох, нөхөн төлүүлэх ажлыг эрчимжүүлж үр дүнд хүрсэн байна. Нийтийн албанд томилогдох эрх нь хасагдсан 579 иргэнийг “жагсаалт”-д бүртгэн томилгооны зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авснаас гадна төрийн байгууллагын ёс зүйн зөвлөл, зөрчлийн мэдээлэл, хяналтын цахим системийг нэвтрүүлсэн байна.

Төрийн албаны зөвлөл, Монгол Улсын Их сургуультай хамтран төрийн албаны хамрах хүрээг бүхэлд нь багтаасан “Төрийн албаны хүний нөөцийн удирдлага” сурах бичгийг гаргасан байна.

Төрийн албаны цахимжуулалтын ажлын хүрээнд E-TAZ аппликейш ашиглагч иргэдийн хэрэглээ нэмэгдсээр байгаа бөгөөд төрийн албаны шалгалтанд бэлтгэгч өөрийн мэдээллээ бүртгүүлэн орж, холбогдох хууль, журамтай танилцах, төрийн албаны шалгалтын жишиг тест бөглөх, загвар үүсгэн өөрийгөө сорих, видео шторк, заавар, шалгалттай холбоотой төрийн албаны зөвлөлөөс бэлтгэн гаргасан ном, товхимол, гарын авлагатай танилцах, татан авах боломжийг үнэ төлбөргүйгээр татан авч ашиглаж байна.

## “e-taz” гар утасны аппликэйшн

Төрийн албаны зөвлөлийн албан ёсны эрхтэй гар утасны аппликэйшн



### Шалгалтад бэлтгэх ном, гарын авлага

Төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалтад бэлтгэхэд унших сорилын ном, бусад ном гарын авлага товхимолуудыг үнэ төлбөргүй татан авч, сүлжээгүй орчин ашиглах боломжтой номын сан бий.



### Сорил бөглөх

Сорил бөглөхийн тулд заавал бүртгүүлнэ. Төрийн албаны шалгалтад ирдэг сорил, тест агуулгаас бүрдсэн сорилуудыг өөрөө үүсгэх, үнэлгээг нь шууд харах боломжтой.



### Видео

Төрийн албаны шалгалтын видео журам, зааврыг оруулсан бөгөөд цэсийг улам өргөжүүлэн шторк, богино хэмжээний видеог тухай бүр оруулна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан видеог оруулна.



### Холбогдох хууль, журам

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдан гарснаас хойших дагалдан гарсан журам, дүрэм, зааврыг үзэх, татан авах боломжтойгоор байршуулсан болно.



### Түгээмэл асуулт, хариулт

Төрийн албаны тухай хууль, дүрэм, журмын талаар иргэдээс ирүүлдэг нийтлэг асуултыг хариултын хамт байршуулсан байх бөгөөд иргэд өөрсдөө асуулт үлдээх боломжтой болно.



### Хэрэглэгчийн мэдээлэл

Гар утасны аппликэйшнд бүртгүүлсэн иргэд өөрсдийн хувийн мэдээллээ үнэн зөв бөглөж бүртгүүлэх бөгөөд сорил даалгавар ажилласан байдал, ном татан уншсан байдал дэлгэрэнгүй статистик гаргадаг болно.



Төрийн албаны шалгалтад бүртгүүлэх, шалгах, дүгнэх зэрэг шалгалтын бүхий л процессыг цахим хэлбэрт шилжүүлснээр хүний оролцоо, хөндлөнгийн нөлөөлөлгүй, олон нийт, мэргэжлийн байгууллагуудын хяналт дор ил тод, нээлттэй байдлыг бүрдүүлсэн байна.

Төрийн албаны тухай хуульд “төрийн захиргааны албаны албан тушаалын тодорхойлолтыг төрийн албаны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн тухайн албан хаагчийг томилох эрх бүхий этгээд албан тушаал тус бүрээр батална” гэж

заасны дагуу төрийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтын хянах үйл ажиллагааг цахимжуулжээ.

Судалгаанд суурилсан “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системийн мэдээллийн чанарыг суурь системүүдтэй интеграци хийж сайжруулсан байна.

Төрийн байгууллагаас үйлчилгээ авсан иргэдийн сэтгэл ханамжийн байдалд үнэлгээ хийж төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны талаар судалгаа авч дүгнэн, үр дүнг тооцож ажилласан байна.

*...Би 2 дахь удаагаа Төрийн албаны шалгалт өнгөрсөн онд өгсөн, өмнө нь нэлээн олон жилийн өмнө өгч байсан юм. Сүүлд шалгалт өгөхөд өмнө нь байдаг байсан шиг зургаа авхуулж угаалгаж очдог, оочерлодог, мэдээлэл авах, шалгалтын хариугаа авах гэж нэлээдгүй дээр дооргүй шахам гүйдэг, цаг хугацаа шаарддаг, хардалт сэрдэлт үүсдэг байсан хүндрэл чирэгдэлтэй зүйлүүд бараг алга байна лээ. Бүртгэлээсээ эхлээд л шалгалт, оноо дүн, шалгалтын хариу гээд л бүхий л үйл ажиллагаа нь цахимжсан, маргаангүй болсон байна лээ. Үйлчилгээний танхим, орчин нөхцөл, тоног төхөөрөмжийн хувьд ч ярих юмгүй болсон байна лээ...*


**ТАЗ-өөр үйлчлүүлсэн иргэнтэй хийсэн ярилцлагаас, 2023 он**


Үйлчилгээний шат дамжлага иргэдэд ойлгомжгүй байх нь иргэдийн цаг хугацаа, санхүү мөнгө зэрэг олон зүйлст нөлөөлж энэ нь эргээд иргэдийн уур бухимдал, сэтгэл ханамжгүй байдлыг үүсгэх шалтгаан болдог байна. Тиймээс байгууллага шат дамжлагаа энгийн ойлгомжтой, нээлттэй байлгах нь нэн чухал асуудал юм.

Шалгалт өгч байсан иргэдээс бүрдүүлэх баримт бичгүүд, үйлчилгээний шат дамжлага хэр байгаа талаар асуумж ярилцлага хийж үзэхэд оролцогчдын дийлэнх хувь нь хүндрэл бэрхшээлтэй зүйл байхгүй, үйлчилгээний дараалал, бүрдүүлэх бичиг баримт ойлгомжтой байсан талаар хэлж байсан болно.

Үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулж, ариун цэврийн өрөө, хүлээлгийн болон шалгалтын танхимын тохижилт, өрөө тасалгааны хаягжилт мэдээлэл авах самбар, тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаатай байдал, дата серверийн аюулгүй байдал зэрэгт анхаарч ажилласан байна.







Мөн төрийн албаны ёс зүйн төлөв байдлын талаар хийсэн судалгаа, шинжилгээний үр дүнг бодлого шийдвэрт тусган ажилласан байна.

Төрийн албаны хууль тогтоомж, шинэтгэлийн үйл явцыг бүх шатанд жигд хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах, бүрэлдэхүүнийг төрийн албаны мэргэшсэн, тогтвортой албан хаагчдаар бүрдүүлж үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахад анхаарч яам, агентлаг, аймаг, нийслэлийн нийт 52 Салбар зөвлөлийг мэргэшил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангаж, хамтран ажиллаж байна.

***Дүгнэлт: Төрийн албаны тухай хууль, “Алсын хараа-2050” бодлогын баримт бичиг, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн албаны шинэтгэлийг эрчимжүүлэх шат дараатай арга хэмжээ авч ажиллаж байгаа тул “Төрийн албаны шинэтгэл” чиг үүргийн хэрэгжилтийг болон Төрийн албаны зөвлөлөөс хийж хэрэгжүүлж буй цахимжуулалтын ажлын хүрээнд хийгдэж буй ажлыг 95% гэж дүгнэв.***

---oOo---

## ДУГНЭЛТ

Төрийн албаны зөвлөл нь 2022 онд Монгол Улсын Их Хурлаас гаргасан зөвлөмж, чиглэл, Төрийн албаны тухай хууль, Монгол Улсын 2050 оныг хүртэлх урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал болох “Алсын хараа 2050”, Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл зэрэг хууль, дүрэм, журам, бодлогын баримт бичгүүдийн үзэл баримтлал, заалтыг удирдлага болгон, хэрэгжилтийг ханган амжилттай ажилласан байна.

Монгол улсад 2022 оны тоо бүртгэлээр нийт 225.205 төрийн албан хаагч ажиллаж байснаас төрийн албаны ангилал тус бүрээр авч үзвэл 1.7% нь төрийн улс төрийн албан тушаалд, 20.9% нь төрийн тусгай албан тушаалд, 9.8% нь төрийн захиргааны албан хаагчид, 67.6% нь төрийн үйлчилгээний албан хаагчид байна.

Зөвлөлийн 2022 оны үйл ажиллагаанд дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

1. Төрийн албаны тухай хууль болон хуульд орсон нэмэлт, өөрчлөлт түүнийг дагалдан гарсан дүрэм, журмын хэрэгжилтийг зохион байгуулах, сурталчлан таниулах, бусад хууль тогтоомжоор хүлээсэн үүргийг биелүүлж ажилласан байна.
2. Төрийн албаны нөөц бүрдүүлэх буюу төрийн албаны ерөнхий шалгалт, төрийн албаны тусгай шалгалт буюу удирдах, гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалтыг цахим технологи ашиглан, хөндлөнгийн нөлөөлөлгүйгээр хараат бус, ил тод, шударга явуулах нөхцөлийг хангаж, шалгалтын агуулга, аргачлал, зохион байгуулалт, арга хэлбэрийн шинэчлэлийг хийсэн байна.
3. Төрийн захиргааны, үйлчилгээний, тусгай зэрэг бүх шатны ангиллын байгууллагын тогтолцоо, бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, албан хаагчдын цалин хөлс, зэрэг дэв, нийгмийн баталгаа гэх мэт олон талт байдалд дүн шинжилгээ хийж, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөө, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх ажлыг арга зүйн зөвлөгөө, удирдлагаар ханган ажиллажээ.
4. Хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд төрийн хүний нөөцийн бодлогын удирдамжаар хангах, төсвийн захиргааны болон хүний нөөцийн менежментийн асуудлаар гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, тэдгээрийн удирдах ажилтныг хууль эрх зүйн болон холбогдох бусад мэргэшил, арга зүйн зөвлөгөө, үйлчилгээгээр хангах үүргээ бүрэн хэрэгжүүлсэн.
5. Монгол улсын төрийн албан хаагчийн тоо бүртгэл мэдээллийн цахим системийг бүрдүүлэх, шинэчлэх, мэдээллээр үйлчлэх үйл ажиллагааг шинэ түвшинд гаргаж, бүрэлдэхүүн, хөдөлгөөний тайлан, статистик мэдээг тухай бүр тогтмол гаргаж хэвшсэн.
6. Томилох эрх бүхий этгээд болон төрийн албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн хооронд хуульд заасан асуудлаар гарсан маргаан болон төрийн жинхэнэ албан хаагчаас цалин хөлс, ажиллах нөхцөл, баталгааны талаар гаргасан бусад маргааныг хууль тогтоомжийн дагуу хянан шийдвэрлэх чиг үүргийг тухай бүр хэрэгжүүлэн ажилласан байна.

7. Маргаан хянан шийдвэрлэсэн Төрийн албаны зөвлөлийн шийдвэрийг холбогдох албан тушаалтан биелүүлээгүй тохиолдолд буруутай албан тушаалтныг үүрэгт ажлаас нь чөлөөлөх мэдэгдлийг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх, төрд учруулсан хохирлыг буруутай албан тушаалтнаар төлүүлэх харилцааг хуульчилсан нь үр дүнгээ өгч эерэг өөрчлөлтүүд гарч эхэлсэн байна.
8. Яам, агентлаг, аймаг нийслэл, салбаруудын төрийн албан хаагчдын нэгдсэн сургалт, семинарт Төрийн албаны зөвлөл оролцож сургалт арга зүйн мэдээлэл, зөвлөгөө өгч, салбар зөвлөлүүдээс салбарын удирдах ажилтны нэгдсэн зөвлөгөөн, төрийн албан хаагчдын чуулга уулзалт, төсөл, хөтөлбөрийн сургалтуудад ажлын албаны ажилтнууд тогтмол оролцсон байна.
9. “Сургалт, судалгаа зохион байгуулах, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх” чиг үүргийн хэрэгжилтийг Төрийн албан хаагчийн хувийн хэрэг, тоо бүртгэлийн нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх, төрийн алба, албан хаагчтай холбоотой мэдээллээр хангах; Төрийн жинхэнэ албан тушаалтныг мэргэшүүлэх багц сургалт, албан тушаалын ажлын байран дахь сургалтын агуулга, хөтөлбөрийн талаар санал боловсруулах; Төрийн албаны судалгаа, шинжилгээний ажлыг зохион байгуулах гэсэн ажлын хэрэгжилт хангалттай сайн хийгдсэн байна.
10. Хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд төрийн хүний нөөцийн бодлогын удирдамжаар хангах, төсвийн захиргааны болон хүний нөөцийн менежментийн асуудлаар гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, тэдгээрийн удирдах ажилтныг мэргэшил, арга зүйн зөвлөгөө, үйлчилгээгээр хангах үүргээ бүрэн хэрэгжүүлсэн.
11. Төрийн албаны тухай хууль тогтоомжид заасны дагуу төрийн байгууллагуудад ёс зүйн зөвлөлүүд байгуулагдан ажиллаж, ёс зүйн зөрчлийн асуудлыг хянан үзээд зохих хариуцлагыг ногдуулж ажилласан байна.
12. Судалгаанд хамрагдсан иргэдийн дийлэнх хувь нь Төрийн албан хаагчийн ерөнхий шалгалтын бүртгэл, асуулга сорил, шалгалт авах шат дамжлага, зохион байгуулалтын арга хэлбэр, техник тоног төхөөрөмж, үйлчилгээний орчин нөхцөл, ажилтнуудын харилцааны соёл, ёс зүйн үнэлгээг эергээр буюу САЙН гэсэн үнэлгээ өгсөн байна.
13. Сонгон шалгаруулж томилж үйл ажиллагааг хуульд нийцүүлэх хяналт, шалгалтуудыг хийж төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж томилсон хууль бус томилгоонуудыг тогтоож зөрчил арилгуулах хугацаатай үүрэг, даалгавар өгч, зөрчил арилгуулах арга хэмжээг авч, хяналт тавин ажилласан.



Төрийн албаны зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайланг үндэслэн дараах 6 үндсэн чиг үүргийн хүрээнд дүнг гаргасан болно. Үүнд:

Д/д	Чиг үүрэг	Үнэлгээ
1	Төрийн жинхэнэ албаны ерөнхий болон тусгай шалгалт зохион байгуулах	95%
2	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	95%
3	Маргаан хянан шийдвэрлэх	95%
4	Сургалт, судалгаа зохион байгуулах, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх	100%
5	Мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгөх	100%
6	Төрийн албаны шинэтгэлтэй холбоотой чиг үүргийн үнэлгээ	95%
<b>Ерөнхий дүн</b>		<b>96.6%</b>

Төрийн албаны зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайлан, холбогдох баримт бичгийн судалгааны үндсэн дээр үнэлгээ хийж, Ерөнхий дүнгээр **96.0% буюу “Маш сайн”** гэж дүгнэж байна.

Тус байгууллагын чиг үүргийн хэрэгжилтийг үнэлэхэд үнэхээр дэвшилттэй, сайшаалтай, ахицтай талууд байсан ч цаашид анхаарвал зохих зарим асуудлууд байгааг дурдах нь зүйтэй. Тухайлбал:

- Төрийн албаны удирдах албан тушаалд хуульд зөрчсөн томилгоо хийснээр төрийн байгууллага, яам, агентлаг, орон нутаг, цаашлаад бүхэл бүтэн салбарын хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж төрийн албан хаагчдын тогтвортой байдал, хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад хүргэх;
- Ихэнх байгууллагын ёс зүйн зөвлөл /хороо/-ийн гишүүдийн чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх бололцоо хангалттай бүрдээгүй, нэмэгдэл урамшуулал цалингүй, зөрчлийг хянан шалгаж, шийдвэрлэх, шийдвэрийг хянах зэрэг үйл ажиллагааны зохицуулалт боловсронгуй бус, уялдаа холбоо сул, зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнг тооцох, хяналт тавих, судалгаа, тайлан мэдээлэл гаргах хугацаа, нийтлэг маягт, загвар зэрэг нь харилцан адилгүй, ёс зүйн зөвлөл /хороо/-ийн мэдээллүүд нь бүрэн бус, үйл ажиллагаа жигд биш явагдаж байна;
- Төрийн албаны сонгон шалгаруулалтын программ хангамжийг сайжруулах төсөв, программын болон сервер тоног төхөөрөмжийн талаар хөндлөнгийн мэргэжлийн байгууллага, шинжээчийн санал, дүгнэлт, мэргэжилтний тодорхойлолт гаргуулах, зориулалтын техник, төхөөрөмжөөр салбар зөвлөлүүдийг хангах, чадавхыг нэмэгдүүлэх;
- Эрхэлсэн ажил, албандаа хариуцлагагүй, өргөсөн тангарагтаа үнэнч бус ханддаг, авлига ашиг сонирхол, ёс зүйн зөрчилд санаатай болон санамсаргүйгээр өртдөг байдлыг таслан зогсоох;
- Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг тогтоосон хугацаанд зохих журмын дагуу үнэлж дүгнэх үйл ажиллагаа хэлбэрийн төдий, тэдгээрийг албан тушаал дэвшүүлэх, цалин хөлсийг өөрчлөх, цол, зэрэг дэв олгох, урамшуулах, зохих шатны сургалтад хамруулах, албан тушаал бууруулах, хариуцлага хүлээлгэх асуудлыг түүний

ажлын гүйцэтгэл, үр дүнг үндэслэн бодитоор шийдвэрлэдэг байдал хангалтгүй;

- Жилийн эцсийн байдлаар төрийн албаны нөхөгдөөгүй орон тооны судалгааг гаргаж, төрийн захиргааны албаны хаагчдын хомсдол, шалтгаан нөхцөлийг судалж тогтоох, цаашид авах арга хэмжээг байнга авч хэрэгжүүлэх;
- Томилох эрх бүхий албан тушаалтнуудын Төрийн албаны тухай болон Захиргааны хууль тогтоомжийн талаарх мэдлэг хангалтгүй, хууль, журмыг зөв ойлгож хэрэглэх асуудал хангалтгүй, албан хаагчийн гаргасан зөрчилд ногдуулах хариуцлагыг зөрчлийн шинж байдалтай уялдуулж, хууль зүйн үндэслэл бүхий шийдвэр гаргаж чадахгүй байгаа зэргийг анхааруулж байна.

---oOo---

## ЗӨВЛӨМЖ

Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагаанд чиг үүргийн үнэлгээ хийсний үндсэн дээр дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1.Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчиж байгаа нийтлэг зөрчлийг арилгах, албан тушаалтнуудыг төрийн жинхэнэ албаны хүний нөөцийн удирдлагатай холбогдуулан гаргах шийдвэрээ хуулийн дагуу гаргах, хууль бус үйлдэл, үйл ажиллагаа явуулахаас урьдчилан сэргийлэх талаар шийдвэр гаргагчдад зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх, сургалт, сурталчилгаа явуулах зэрэг үр дүнтэй арга хэмжээг үргэлжлүүлэн явуулах;

2.Төрийн улс төрийн албан тушаалтан буюу аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, ИТХ-ын дарга, төрийн захиргааны албан тушаалд томилогдон ажиллаж буй ИТХ-ын төлөөлөгч нар намын харьяаллаар хууль зөрчиж томилгоо хийх явдлыг таслан зогсоох, төрийн албыг улс төрөөс ангид байх зарчмыг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг байнга авч ажиллах;

3.Орон нутаг дахь нөхөгдөхгүй байгаа сул орон тооны мэдээллийг их дээд сургууль төгсөгчдөд хүргэх, чухал шаардлагатай болон нарийн мэргэжлийн эрэлт нийлүүлэлтийг судлах, иргэд олон нийтэд мэдээлэх;

4.Албан хаагчдын ёс зүй, харилцааны соёлыг дээшлүүлэх талаар тогтмол сургалт явуулах, байгууллагын үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах, хэрэгжилтэд үйлчлүүлэгчдээр болон хөндлөнгийн байгууллагаар тогтмол үнэлгээ, судалгаа хийлгэж хэвших;

5.Төрийн байгууллагуудын Ёс зүйн зөвлөлийн гишүүдийг томилох, чөлөөлөх, хараат бусаар ажиллах нөхцөл бололцоогоор хангах, урамшуулах тогтолцоог дүрэмд заавал тусгаж өгөх, Төрийн албаны зөвлөлийн дэргэд байгууллагуудын ёс зүйн зөвлөлийн хариуцсан тусгай бүтэц бий болгох боломжийг судлах;

6.Төрийн байгууллагуудын зарим албан тушаалууд нь хоорондоо үүрэг хариуцлагын түвшин, үнэлэмжээр ижил төстэй боловч тэдгээрт ажиллаж буй албан хаагчдын цалин хөлс, зэрэг дэвийн болон бусад нэмэгдэл урамшуулал нь харилцан адилгүй, ялгамжтай байгаа тохиолдол байна. Иймд ижил зэрэглэл, үнэлэмжтэй ажилд адил цалин хөлс олгох үндсэн зарчмыг баримталж ажиллах талаар холбогдох бүх төрлийн судалгааг гаргаж, цалин хөлсний бодлогыг шинэчлэн авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

---oOo---